




Insightful  
Innovative  
Strategic



СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЖИШЭЭН ДЭЭР

“МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ  
ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН  
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨГ ХЭМЖИХ  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН





# RESEARCH COMPANY

## **ГЕРМАНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ (GIZ)**

Монгол, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,

City Tower Building, 12 давхар, 1202 тоот өрөө

Утас: (976)-11-77110515, (976)-11-70041890

И-мэйл хаяг: [giz-mongolei@giz.de](mailto:giz-mongolei@giz.de)

Веб сайт: <http://www.giz.de>

## **ЭМ ЭМ СИ ЖИ ХХК**

Зүүн хүрээ хотхон, 203-р байр, 4 давхар, 14-р хороо

Баянзүрх дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс

Утас/Факс: 976-77000188

И-мэйл хаяг: [info@mmcg.mn](mailto:info@mmcg.mn)

Веб сайт: <http://www.mmcg.mn>





## АГУУЛГА

01

СУДЛАГДСАН  
БАЙДЛЫН  
ШИНЖИЛГЭЭ

02

СУДАЛГААНЫ  
АРГАЧЛАЛ, ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТ

03

ДУЛААН ТЕХНИКИЙН ИХ  
ЗАСВАРЫН АЖЛЫН ХҮРЭЭНД  
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

04

ХАМААРЛЫН  
ШИНЖИЛГЭЭ

05

ҮНЭЛГЭЭНИЙ  
ДЭЛГЭРЭНГҮЙ  
ҮР ДҮН

06

НИЙГЭМ, ЭДИЙН  
ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ

## АГУУЛГА

<b>I. УДИРТГАЛ</b> .....	<b>vi</b>
<b>Хураангуй үр дүнгийн хүснэгт</b> .....	<b>vii</b>
<b>II. Судлагдсан байдлын шинжилгээ</b> .....	<b>2</b>
2.1. Дотоодод судлагдсан байдал .....	2
2.2. Олон улсад судлагдсан байдал.....	4
<b>III. Судалгааны аргачлал, мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт</b> .....	<b>8</b>
3.1. Судалгааны аргачлал.....	8
3.2. Судалгааны хамрах хүрээ .....	8
3.3. Мэдээлэл цуглуулалт болон хэрэгжилт .....	9
3.3.1. Судалгааны бэлтгэл ажлыг хангасан байдал .....	10
3.4. Мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт .....	11
3.5. Мэдээлэл цуглуулалтын чанарын хяналт .....	11
3.6. Мэдээллийн сан үүсгэх, тайлан боловсруулалт .....	12
<b>IV. Сургууль, цэцэрлэгийн дулаан техникийн их засварын ажлын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд</b> .....	<b>14</b>
4.1. Сургууль, цэцэрлэгийн их засварын хөрөнгө оруулалтын бүртгэлийн систем 14	
4.2. Удирдлага, багш, эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ .....	14
4.3. Засвар, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэл.....	15
4.4. Төсөл хэрэгжсэн дүүргүүдийн тоон үзүүлэлт .....	16
<b>V. Хамаарлын шинжилгээний үр дүн</b> .....	<b>19</b>
5.1. Цэцэрлэгийн хүүхдэд үзүүлсэн нөлөө .....	20
5.1.1. Дулаан техникийн засварын ажлын нөлөө.....	20
5.1.2. Дотоод орчны нөлөө.....	20
5.1.3. Сэтгэлзүй, зан төлөв ба сурлагын идэвх хоорондын хамаарал.....	20
5.2. Сургуулийн хүүхдэд үзүүлсэн нөлөө .....	23
5.2.1. Дулаан техникийн засварын ажлын нөлөө.....	23
5.2.2. Дотоод орчны температур .....	23
5.2.3. Дотоод орчны нөлөө.....	23
5.2.4. Сэтгэлзүй, зан төлөв ба сурлагын идэвх хоорондын хамаарал.....	23
5.3. Багш нарт үзүүлсэн нөлөө.....	26
5.3.1. Дулаан техникийн засварын ажлын нөлөө.....	26
5.3.2. Дотоод орчны температур .....	26
5.3.3. Дотоод орчны нөлөө.....	26
5.3.4. Сэтгэлзүй, зан төлөв болон багшийн ажлын бүтээмж хоорондын хамаарал... 26	
<b>VI. Судалгааны дэлгэрэнгүй үр дүн</b> .....	<b>28</b>
6.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл .....	28

6.2. Төсөл хэрэгжсэн сургууль цэцэрлэгийн орчны тав тухын үнэлгээ .....	31
6.3. Төсөл хэрэгжээгүй сургууль цэцэрлэгийн орчны тав тухын үнэлгээ .....	35
6.4. Төсөл хэрэгжсэн болон хэрэгжээгүй сургууль цэцэрлэгийн орчны үзүүлэлтүүдийн харьцуулсан үнэлгээ .....	38
<b>VII. Нийгэм, эдийн засгийн нөлөөлөл.....</b>	<b>40</b>
7.1. Сурагчдад үзүүлсэн нийгмийн нөлөөлөл .....	41
7.2. Сурагчдын сурлагын идэвх (Төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургууль, цэцэрлэгээр) .....	42
7.3. Сурагчдын сэтгэл санаа, сэтгэлзүй (Төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургууль, цэцэрлэгээр) .....	43
7.4. Эрүүл мэндийн нөлөөлөл (Төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургууль, цэцэрлэгээр).....	44
7.5. Эдийн засгийн үр нөлөө .....	47
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>48</b>
<b>Хүснэгтийн жагсаалт</b>	
Хүснэгт 1. Дотоодод судлагдсан байдлын хураангуй.....	3
Хүснэгт 2. Олон улсад судлагдсан байдлын хураангуй .....	5
Хүснэгт 3: Үнэлгээний хувьсагчид, түүнд хамаарах үзүүлэлтүүд .....	19
Хүснэгт 4: Дулаан техникийн засварын ажлын шууд нөлөө, цэцэрлэгийн орчинд...	21
Хүснэгт 5: Дулаан техникийн засварын ажлын шууд бус нөлөө, цэцэрлэгийн орчинд .....	21
Хүснэгт 6: Дулаан техникийн засварын ажлын шууд нөлөө, сургуулийн орчинд .....	24
Хүснэгт 7: Дулаан техникийн засварын ажлын дам шууд нөлөө, сургуулийн орчинд .....	24
Хүснэгт 8: Дулаан техникийн засварын ажлын багш нарт үзүүлж буй шууд нөлөө .	27
Хүснэгт 9: Дулаан техникийн засварын ажлын багш нарт үзүүлж буй шууд бус нөлөө .....	27
Хүснэгт 10 Түүвэрт эзлэх хувь, сургуулиар.....	28
Хүснэгт 11. Өрхийн сарын дундаж орлого .....	30
Хүснэгт 12. Сургууль, цэцэрлэгт дулаан техникийн ажил хийгдсэн талаар мэдэж байгаа эсэх, судалгаанд оролцогчдоор.....	30
Хүснэгт 13. Сургууль, цэцэрлэгийн орчинд сэтгэл ханамжгүй байсан хүчин зүйлс .	31
Хүснэгт 14. Төсөлд хамрагдсан сургууль цэцэрлэгийн орчны тав тухын харьцуулан үнэлгээ.....	32
Хүснэгт 15. Төсөл хэрэгжсэн сургууль, цэцэрлэгүүдийн өмнө нь тулгардаг байсан асуудлууд .....	34
Хүснэгт 16. Сургууль, цэцэрлэгийн орчны температурын сэтгэл ханамж, сургуулиудаар .....	36
Хүснэгт 17. Төсөлд хэрэгжээгүй сургууль, цэцэрлэгүүдэд тулгарч буй асуудлууд. .	37



Хүснэгт 18. Орчны үнэлгээ, төсөл хэрэгжсэн болон хэрэгжээгүй сургууль, цэцэрлэгээр.....	38
Хүснэгт 19. Төсөл хэрэгжсэн болон хэрэгжээгүй сургуулийн орчны үнэлгээ, сурагчдаар.....	39
Хүснэгт 20. Төсөл хэрэгжсэн болон хэрэгжээгүй сургуулийн орчны үнэлгээ, багш нараар.....	39
Хүснэгт 21. Дулаан, техникийн ажил хийгдсэнээр гарсан эерэг өөрчлөлтүүд.....	41
Хүснэгт 22. Дулаан, техникийн ажил хийгдсэнээр гарсан эерэг өөрчлөлтүүд.....	41
Хүснэгт 23. Сурагчдын хичээл завсардсан шалтгаан .....	42
Хүснэгт 24. Сурагчдын сурлагын идэвх, төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургууль, цэцэрлэгээр.....	42
Хүснэгт 25. Сурагчдын сэтгэл зүй, сэтгэл санааны байдал .....	43
Хүснэгт 26. Сурагчдын сэтгэл зүй, сэтгэл санааны байдал, төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургуулиар .....	43
Хүснэгт 27. Өвчлөлийн төрөл, төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургууль, цэцэрлэгээр.....	44
Хүснэгт 28. Өвчилсөн давтамж, төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургууль, цэцэрлэгээр.....	45
Хүснэгт 29. Нэг удаагийн эмчилгээнд зарцуулсан зардал, хувь, дунджаар .....	46
Хүснэгт 30. Нэг удаагийн эмчилгээний зардал, төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургууль, цэцэрлэгээр .....	46
Хүснэгт 31. Анги, танхимд мөнгө хураадаг давтамж, төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургууль, цэцэрлэгээр .....	47
Хүснэгт 32. Сургууль, цэцэрлэгт хураалгадаг зардал, төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургууль, цэцэрлэгээр .....	47
Хүснэгт 33: Судалгаанд хамрагдсан цэцэрлэгүүдийн суралцагчид, багш, ажиллагчдын тоо, 2020-2021 оны хичээлийн жилд .....	48
Хүснэгт 34: Судалгаанд хамрагдсан сургуулиудын суралцагчид, багш, ажиллагчдын тоо, 2020-2021 оны хичээлийн жилд .....	48
Хүснэгт 35: Судалгаанд хамрагдсан цэцэрлэгүүдийн ачааллын үзүүлэлтүүд, 2020-2021 оны хичээлийн жилд .....	49
Хүснэгт 36: Судалгаанд хамрагдсан сургуулиудын ачааллын үзүүлэлтүүд, 2020-2021 оны хичээлийн жилд .....	49
Хүснэгт 37: Төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэгүүдийн мэдээлэл.....	50
Хүснэгт 38: Төсөлд хамрагдсан цэцэрлэгүүдийн хамран сургах тойрог, холбогдох статистик мэдээлэл.....	50
Хүснэгт 39: Төсөлд хамрагдсан сургуулиудын хамран сургах тойрог, холбогдох статистик мэдээлэл.....	51
Хүснэгт 40: Агаарын чанарын статистик үзүүлэлтүүд, 2017-2020 оны 2 дугаар саруудын дунджаар .....	52
Хүснэгт 41: Нийслэлийн хүн ам зүйн статистик үзүүлэлтүүд, дүүргээр .....	53
Хүснэгт 42: Нийслэлийн хүн амын эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд, дүүргээр, 2020 оны эцэст .....	53

Хүснэгт 43: Нийслэлийн СӨБ, ЕБС-д хамрагдагчдын тоо, дүүргээр, 2020 оны эцэст .....	53
---	----

## Зургийн жагсаалт

Зураг 1. Таблет ашиглан судалгаа авах процесс .....	8
Зураг 2. Судалгааны хамрах хүрээ, тоогоор .....	8
Зураг 3 Төсөл хамрагдсан сургууль цэцэрлэгийн нийлбэр тоо, дүүргээр .....	9
Зураг 4. БЗД-ээс төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэг .....	9
Зураг 5 СХД-ээс төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэг .....	9
Зураг 6. Төсөлд хамрагдаагүй сургууль, цэцэрлэг .....	9
Зураг 7. Сургалтын үйл ажиллагаа .....	10
Зураг 8. Бэлтгэсэн программын харагдах байдал .....	11
Зураг 9. SPSS датаны харагдах байдал .....	12
Зураг 10: Дулаан техникийн засварын ажлын шууд болон шууд бус нөлөө, цэцэрлэгийн орчинд .....	20
Зураг 11: Дулаан техникийн засварын ажлын үзүүлсэн нөлөө, сургуульд .....	24
Зураг 12. Сургууль, цэцэрлэгийн орчинд сэтгэл ханамжгүй байсан үзүүлэлтүүд ....	31

## Графикийн жагсаалт

График 1. Судалгаанд хамрагдсан бүлгүүд, хүйсээр .....	28
График 2. Судалгаанд хамрагдсан сурагчид, ангийн бүлгээр .....	29
График 3. Хүүхдүүдийн асран хамгаалагч, аав, ээж .....	29
График 4. Судалгаанд хамрагдсан дүүрэг, сурагчдаар .....	29
График 5. Багш нарын ажилласан жил .....	29
График 6. Судалгаанд оролцогчдын амьдардаг сууцны төрөл, түүвэрт эзлэх хувиар .....	30
График 7. Асуудлуудын шийдвэрлэгдсэн байдал болон сэтгэл ханамж .....	32
График 8. Орчны тав тухын сэтгэл ханамж, судалгаанд оролцогчдын бүлгээр .....	33
График 9. Орчны температурт тухтай байдал, төсөл хэрэгжсэн болон хэрэгжээгүй сургууль, цэцэрлэгээр .....	35
График 10. Ханиад, томуу нь сургуулийн орчноос шалтгаалсан эсэх .....	44
График 11. Ханиад, томуу нь сургуулийн орчноос шалтгаалсан эсэх .....	44

## Схемийн жагсаалт

Схем 1: Судалгааны загвар .....	6
Схем 2. Дулаан техникийн засварын ажлын цэцэрлэгийн хүүхдэд үзүүлж буй нөлөө, SmartPLS, SEM model, шууд хамаарлын үр дүн .....	22
Схем 3: Дулаан техникийн засварын ажил нь сургуулийн сурагчдад үзүүлж буй нөлөө, SmartPLS, SEM model, шууд нөлөөний үр дүн .....	25
Схем 4: Дулаан техникийн засварын ажлын багш нарт үзүүлж буй нөлөө, SmartPLS, SEM model, шууд нөлөөний үр дүн .....	27

## Товчилсон үгсийн жагсаалт

CATI	CATI- Computer-Assisted Telephone Interview
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТХО	Төсвийн хөрөнгө оруулалт



## УДИРТГАЛ

Монгол Улс нь эрс тэс уур амьсгалтай, зун богинотой, өвөл урттай, хүйтэн байдгаараа онцлогтой. Дулаан хангамж нь нүүрсэнд суурилсан шийдэлтэйгээс гадна тоног төхөөрөмж нэлээд хуучирсан мөн барилгын дулаалга муутайгаас нийслэл Улаанбаатар хот хүйтний улиралд нүүрсний утааснаас үүдэлтэй тортогжилт, агаарын бохирдол ихтэй байдаг. Түүнчлэн өвлийн хүйтэнд нийтийн зориулалттай сургууль, цэцэрлэгийн дотоод агаарын хэм бага байх нь сурагчид болон ажилчдын эрүүл мэндэд онцгой сөрөг үр дагавартай байдаг.

Тиймээс Швейцарын хөгжлийн агентлаг /SDC/, Германы Хамтын Ажиллагааны /BMZ/ санхүүжилтээр Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь” төслийг /2018-2021/ Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн.

Иймээс Үндэсний судалгааны “Эм Эм Си Жи” ХХК нь “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн дулаан техникийн засвар шинэчлэлтийн ажлын үр ашгийг тодорхойлох судалгааг хийж гүйцэтгэлээ. Тус судалгаанд төсөл

хэрэгжсэн Баянзүрх, Сонгинохайрхан болон Налайх дүүргүүдэд байрлалтай 5 сургууль, 13 цэцэрлэгийн сурагчид, тэдгээрийн эцэг эх, багш ажилчид хамрагдлаа. Мөн сэтгэл ханамжийн индексүүдийг харьцуулах зорилгоор төсөл хэрэгжээгүй 2 цэцэрлэг, 2 сургуулийн сурагчид, тэдгээрийн эцэг эх, багш ажилчдыг хамруулав. Судалгааны хүрээнд дулаан техникийн засвар шинэчлэлтийн ажил хийгдсэнээр сургууль, цэцэрлэгийн сурагчид, тэдгээрийн эцэг, эх багш, ажилчдын амьдралд ахуйд үзүүлсэн нийгэм, эдийн засгийн нөлөөг хэмжихэд зөвлөх үйлчилгээний зорилго оршино.

Судалгааны мэдээлэл цуглуулалт нь үндсэн 3 үе шатаас бүрдэнэ. Үүнд:

- Сургууль цэцэрлэгийн удирдлагуудыг оролцуулсан ганцаарчилсан ярилцлага,
- Төсөлд хамрагдсан болон төсөлд хамрагдаагүй сургууль, цэцэрлэгийн сурагчид, тэдгээрийн эцэг, эхийг оролцуулсан фокус бүлгийн ярилцлага болон тоон судалгаа

Мэдээлэл цуглуулалтын ажлыг 2022 оны 3 дугаар сарын 4-с 3 дугаар сарын 14-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Мэдээлэл цуглуулалтыг судалгааны олон улсын ёс зүйн стандарт болох ESOMAR, нийгмийн болон зах зээлийн судалгааны олон улсын стандарт болох ISO 20252:2019-г баримтлан зохион байгуулав.

## Хураангуй үр дүнгийн хүснэгт

Шалгуур үзүүлэлтүүд	Оролцогч талууд			Төсөлд хамрагдсан эсэх		Сургууль цэцэрлэгийн төрөл		Нийт
	Эцэг, эх	Сурагч	Багш	Хамрагдаагүй	Хамрагдсан	Цэцэрлэг	Сургууль	
<b>Ажил/Сурлагын идэвх (Performance)</b>	<b>8.72</b>	<b>7.92</b>	<b>9.52</b>	<b>8.44</b>	<b>8.46</b>	<b>9.00</b>	<b>8.16</b>	<b>8.46</b>
Хичээлдээ/ажилдаа сонирхолтой, дуртай байдал	9.26	8.59	9.81	9.04	9.13	9.42	8.93	9.12
Сурлагын дүн/ажлын амжилт	8.59	7.71	9.42	8.38	8.42	9.05	8.01	8.41
Хичээлдээ/ажилдаа анхаарал төвлөрөх байдал	8.31	7.45	9.34	8.02	8.18	8.74	7.79	8.15
<b>Зан төлөв, сэтгэл зүй (Behaviour)</b>	<b>9.12</b>	<b>8.01</b>	<b>8.91</b>	<b>8.49</b>	<b>9.14</b>	<b>9.27</b>	<b>8.75</b>	<b>8.99</b>
Сургууль, цэцэрлэг дээр байхад аюулгүй санагдах байдал	8.90	8.85	9.40	8.51	9.02	9.32	8.69	8.93
Сэтгэл санааны байдал, стресс	8.99	7.00	8.60	7.96	8.46	9.05	7.95	8.37
Оюун санааны ядаргаанд орох байдал	8.76	6.10	7.98	7.51	7.99	9.10	7.17	7.91
Бусад хүүхдүүд, багш нартай харилцаатай байдал	9.17	8.80	9.78	9.13	9.12	9.36	8.97	9.12
Эцэг, эх, гэр бүлийн гишүүдтэй харилцаатай байдал	9.68	8.78	9.61	9.22	9.45	9.64	9.27	9.41
Эрүүл мэндийн байдал	9.23	8.49	8.07	8.56	8.97	8.98	8.85	8.90
Өөртөө итгэлтэй байдал	9.10	8.05		8.62	9.08	9.34	8.65	8.97
Сургуулийн орчноос ичдэг байдал	9.17	8.43		8.39	9.30	9.15	9.02	9.08
<b>Өвчилсөн тоо (Illness)</b>	<b>0.82</b>	<b>0.53</b>	<b>1.12</b>	<b>0.82</b>	<b>0.75</b>	<b>1.13</b>	<b>0.54</b>	<b>0.76</b>
<b>Эцэг эхийн анхаарал, халамж (Parents attention)</b>	<b>9.33</b>	<b>7.88</b>		<b>8.84</b>	<b>8.87</b>	<b>9.38</b>	<b>8.58</b>	<b>8.86</b>
Эрүүл мэндэд анхаарал хандуулах	9.62	8.75		9.36	9.33	9.56	9.22	9.34
Сэтгэл санааны байдалд анхаарал хандуулах	9.39	7.51		8.61	8.82	9.48	8.40	8.78
Сурлагад анхаарал хандуулах	9.26	7.87		8.83	8.81	9.36	8.51	8.81
Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцох	9.06	7.38		8.55	8.51	9.12	8.19	8.52
<b>Дотоод орчны сэтгэл ханамж (Indoor Environment Satisfaction)</b>	<b>8.05</b>	<b>7.63</b>	<b>8.50</b>	<b>6.79</b>	<b>8.22</b>	<b>8.47</b>	<b>7.66</b>	<b>7.97</b>
Орчны тав, тух	8.36	8.00	8.87	6.62	8.66	8.76	8.02	8.30
Орчны температур, өвлийн улиралд	8.67	8.25	8.66	6.89	8.90	8.77	8.41	8.55
Орчны температур, зуны улиралд	8.24	7.98	9.27	7.48	8.42	8.73	7.97	8.26
Орчны температурын үнэлгээ, одоогийн байдлаар	8.22	7.58	8.57	6.70	8.36	8.41	7.86	8.06
Агаарын чанар	7.12	7.09	7.49	5.83	7.43	7.66	6.83	7.15

Гэрэлтүүлэг	8.59	8.27	8.99	7.55	8.74	8.83	8.35	8.53
Ариун цэврийн өрөө	7.22	5.82	7.76	5.83	7.08	8.33	5.95	6.86
Анги танимын доторх тохижилт	8.43	8.21	8.91	7.47	8.61	8.83	8.15	8.41
Зай талбай	7.42	7.89	8.12	6.61	7.84	8.02	7.38	7.63
Доторх орчны дуу чимээ	8.21	7.18	8.38	6.89	8.14	8.33	7.67	7.92
<b>Гадна орчны сэтгэл ханамж (Outdoor Environment Satisfaction)</b>	<b>7.05</b>	<b>6.89</b>	<b>7.67</b>	<b>5.86</b>	<b>7.32</b>	<b>7.43</b>	<b>6.83</b>	<b>7.06</b>
Гадна орчны дуу чимээ	6.96	6.81	7.48	5.80	7.21	7.28	6.77	6.97
Гаднах орчны нөхцөл байдал	7.14	6.97	7.86	5.92	7.42	7.59	6.89	7.16
<b>Дулаан техникийн засвар шинэчлэлтийн ажлын чанар (Quality of the Thermo-Technical Refurbishment)</b>	<b>8.80</b>	<b>8.68</b>	<b>8.46</b>	<b>8.20</b>	<b>8.76</b>	<b>8.91</b>	<b>8.58</b>	<b>8.73</b>



# БҮЛЭГ 1: СУДЛАГДСАН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ



# I. Судлагдсан байдлын шинжилгээ

## 1.1. Дотоодод судлагдсан байдал

Сургууль, цэцэрлэгийн орчныг сайжруулснаар сурагчид, тэдгээрийн эцэг, эх, багш, ажилчдын нийгэм эдийн засгийн төлөв байдалд үзүүлж буй нөлөөллийн талаар олон улсад болон

дотоодод хийж гүйцэтгэсэн ижил төстэй судалгааны ажлын баримт бичгүүдтэй танилцаж тэдгээрийн судалгааны арга зүйг судаллаа.

### ДОТООДОД ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАНГУУД

**Бодлогын хураангуй** 

№ 227 2020 оны 8-р сар

**Улсын цэцэрлэгийн хөтөлбөр нь эхийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулдаг**

М.Л.Алзуу, Б.Аманцэрлэг, А.Гантуулсайх, С.Давбадрах, Х.Лосодог, В.Сойноо

**Судалгааны үр дүн**

- Улсын цэцэрлэгт хүүхдэд хамруулсан нь эцэг эхийн, аялгуу эзний хөдөлмөр эрхлэлтийн түвшин болон сарын цөлөг өсөдөг.
- Улсын цэцэрлэгт хүүхдэд хамруулдаг эцэг эхийн албан захирал ажиллаж мэддэгт өндөр байна.
- Эцэстэй тасалбар хөдөлгөөний олон тооны хүүхдэд улсын цэцэрлэгт хамрагдажээ.
- Эцэстэй тасалбар хөдөлгөөн орон төр юмсанж хүүхдийн цэцэрлэгт хамрагдах боломжийн талы байдлыг сайжрууна.

**Хүүхдэд орох нь эмэгтэйчүүдийн амжилт хүчин оролцоог хязгарладаг**

Монголын эмэгтэйчүүдийн амжилт, өсөлтөд эрчүүдийн хамт оролцоо нь голчлон эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтэй холбоотой байна. Хүүхдэд орох нь эмэгтэйчүүдийн амжилтыг дэмжжээ. Хүүхдэд орох нь эмэгтэйчүүдийн амжилтыг дэмжжээ. Хүүхдэд орох нь эмэгтэйчүүдийн амжилтыг дэмжжээ.



**Сургуулийн өмнө боловсролын хөтөлбөр**

Сургуулийн өмнө боловсролын (СӨБ) хөтөлбөр нь үндэс дээр үндэс, өндөр хүүхдэд орох үйлчилгээг өгөх боломж болгодог. Эх хөтөлбөр нь хүүхдийн гадаргуу болон хөдөлгөөн чөлөөтэй байхыг хангана. Хүүхдэд орох нь эмэгтэйчүүдийн амжилтыг дэмжжээ.

СӨБ нь хөтөлбөр хүүхдийн сэтгэл санааг дэмжжээ. Хүүхдэд орох нь эмэгтэйчүүдийн амжилтыг дэмжжээ.

СӨБ нь хөтөлбөр хүүхдийн сэтгэл санааг дэмжжээ. Хүүхдэд орох нь эмэгтэйчүүдийн амжилтыг дэмжжээ.

СӨБ нь хөтөлбөр хүүхдийн сэтгэл санааг дэмжжээ. Хүүхдэд орох нь эмэгтэйчүүдийн амжилтыг дэмжжээ.

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДЭЙН ГАЗАР

**“ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН ДОТООД ОРЧНЫ АГААРЫН ЧАНАР ХҮҮХДИЙН АМЬСГАЛЫН ЗАМЫН ӨВЧЛӨЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ” судалгааны тайлан**



**ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДЭД АГААРЫН БОХИРДЛЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**



Улаанбаатар хот 2020 он

2019 он

**ЭЦСИЙН ТАЙЛАН**

СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ДУЛААН ТЕХНИКИЙН ЗАСВАР ШИНЖЛЭЛТИЙН АЖЛЫН НИЙГМИЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮР АШГИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

Амангүдүүл: Н.Энхийаа  
Туслах судлаач: Т.Индрихаа

2020 он

**БИДНИЙ ТУРШЛАГА-2020**

Нийслэлийн цэцэрлэг, сургуулийг засварлаж, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх эцэг эх, иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлсэн сайн туршлагыг эмхэтгэл



2020 он

“МОНГОЛ ДАХЬ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН “ЭЦЭГ ЭХИЙН ОРЛОЛТОТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШИНЖЛЭГЭЭ, ҮНЭЛГЭЭ”-НИЙ АРГАЧЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ДИМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИГЭЭНИЙ ЭЦСИЙН ТАЙЛАН

Лаяга овортой Монгол мөнх бие НЭДТГ, Германы Олон Утсан Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ээс 2016-2021 онд зэрэглүүлж байгаа “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд НЭДТГ, 9 дүргийн боловсролын хэлтэс, төслийн 3 сургууль, төслийн бүс 4 цэцэрлэг, 3 сургууль 10 цэцэрлэг, сургуульд “Эцэг эхийн оролцоот” үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ”-ний аргачлал хэрэгжүүлэхэд димжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэжээ.

**Энэхүү зөвлөх үйлчилгээний хүрээнд:**

- НЭДТГ, 9 дүргийн боловсролын хэлтэс, 10 цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш, ажилтан, эцэг эхийн төлөөлөл бусад “Дэмжин бэг”-ийн “Эцэг эхийн оролцоот” үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ыг зохиож сургалт зохион байгуулав;
- Гадаад дотоодын орчны аюулгүй байдал, бодлогын эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд зөвлөх туслах;
- Төсөлд хамрагдсан цэцэрлэг, сургуулийн Нийслэлийн бусад цэцэрлэг, сургуульд төслийн хүрээнд бий болгосон сайн туршлагаг хуваахад, харилцан суралцахад димжлэг үзүүлэх;
- Төслийн хүрээнд бий болгосон сайн туршлагаг хуваахад, харилцан суралцахад димжлэг үзүүлэх;
- 2021 оны 9 сарын 30-аас 12 сарын 10-ыг хүртэл хуваагдай барааг ажилыг гүйцэтгэхэд анхаарч ажиллав.

**Түнд:**

**А. Зөвлөх туслах:** Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн “Боловсролын хэлтэсийн мэргэжилтнүүдийг дургүйцээ цэцэрлэг, сургуульд” “Эцэг эхийн оролцоот” үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ыг хэрэгжүүлэхэд зөвлөх туслах, сургалт зохион байгуулах, арга зүйн димжлэг үзүүлэх болон 2021 онд аргачлалыг туршиж хэрэгжүүлж байгаа 10 цэцэрлэг, сургуульд зөвлөх туслах димжлэг үзүүлэх;

**Б. Үндэсний ажлуучууд:** Нийслэлийн боловсролын газрын өвчлөлт болон нэрвэл оролцоотой зөвлөх мэдээлэл бүртгэлийн системд тодорхой эрч хүчин төслийн хүрээнд боловсруулсан гарын авлага, видео, мэдээлэл, материалыг нэгтгэн, тусгай дэлгэрүүлэх;

**В. Мэдээлэл сурталчилгаа:** Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төслийн хүрээнд цэцэрлэг, сургуульдаа хэрэгжүүлсэн үйл ажиллагааг бүрэн хүртэж болгох;

**Г. Сайн туршлага-Тогтвортой байдлыг хангах:** Төсөл хэрэгжүүлж байгаа 10 цэцэрлэг, сургуулийн сайн туршлагаг хуваахад бие биеэсээ харилцан суралцаж боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ Нийслэлийн боловсролын газраас “Эцэг эхийн оролцоот” үр дүнд

## Хүснэгт 1. Дотоодод судлагдсан байдлын хураангуй

<b>Судлаач №1</b>	<b>Эм Эм Си Жи ХХК</b>
Судалгааны ажлын нэр, он	“Төсвийн хөрөнгө оруулалтыг сайжруулснаар эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь” төслийн II үе шатны суурь судалгаа, 2019
Судалгааны ажлын зорилго	<p>Төслийн мониторинг үнэлгээний төлөвлөгөөнд тусгагдсан дараах гол хоёр үзүүлэлттэй холбогдох мэдээллийг цуглуулж, нэгтгэн дүгнэхэд чиглэгдсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийгмийн салбарын дэд бүтэц, нэн ялангуяа сургууль, цэцэрлэгийн барилгын чанарыг сайжруулахад ил тод, үр дүнтэй, жендерийн мэдрэмжтэй ТХОУ-ыг нийслэл Улаанбаатар хотод тууштай нэвтрүүлэх;</li> <li>• Эрчим хүчний үр ашигтай, дулааны алдагдлыг бууруулах технологийг нийслэлийн боловсролын салбарт жишиг болгон нэвтрүүлэх;</li> </ul>
Судалгааны ажлын арга зүй	<p>Нийт 35 ганцаарчилсан ярилцлага хийсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ НЗДТГ-ын удирдлага, албан хаагчид, Дүүргийн ЗДТГ болон холбогдох хэлтэс, албаны удирдлага, албан хаагчид, Баянзүрх дүүрэг болон Сонгинохайрхан дүүргийн төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчдээс ярилцлага авсан.</li> </ul>
Судалгааны ажлын үр дүн	<p><b>Сургууль, цэцэрлэгийн барилгын засвар үйлчилгээ:</b> Төсөв санхүүжилт хангалтгүй байдгаас сургууль цэцэрлэгийн засвар үйлчилгээ хангалттай хийдэггүй. Урсгал засвар, их засвар, өргөтгөлийн ажлын талаар нэгдсэн мэдээлэл судалгаа байдаггүйгээс төлөвлөлт буруу, хөндлөнгийн нөлөө ордог, үр дүнтэй ажил болдоггүй гэж оролцогч талууд үзжээ.</p> <p><b>Сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан алдагдлыг бууруулах засвар үйлчилгээ:</b> Төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд уг асуудлыг шийдвэрлэж байгаагүй, харин олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр энэ орон зайг нөхөж ажиллаж байна. Сургууль, цэцэрлэгийн дулаан, цахилгааны зардал төсвийн зардалд өндөр хувийн жинг эзэлдэг, сургалтын таатай орчин бүрдүүлэх тал дээр тулгамдаж буй асуудал болж байсныг энэ чиглэлийн төсөл хөтөлбөрүүд шийдвэрлэж өгч байна. Оролцогч талуудын ойлголт хандлага ч өөрчлөгдөж байгаа нь энэ чиглэлийн төслийг хэрэгжүүлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлж байна.</p>
<b>Судлаач №2</b>	<b>Ахлах судлаач Н.Эгиймаа</b>
Судалгааны ажлын нэр, он	Сургууль, цэцэрлэгийн дулаан техникийн засвар шинэчлэлтийн ажлын нийгмийн болон эрүүл мэндийн үр ашгийг тодорхойлох судалгаа, 2019
Судалгааны ажлын зорилго	“Төсвийн хөрөнгө оруулалтыг сайжруулснаар эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд 2018 онд 53 дугаар сургууль, 90 болон 127 дугаар цэцэрлэгүүдэд хийгдсэн барилгын дулаан техникийн засвар шинэчлэлтийн ажил хийгдсэнээр хүүхдүүд, эцэг эх, багш, ажилчдад гарсан нийгэм, эрүүл мэнд, эдийн засгийн үр ашгийг тодорхойлох. Мөн

2019 онд засвар шинэчлэлт хийгдэх төрийн өмчийн 6 сургууль, цэцэрлэгт гарах үр нөлөөг хэмжих бэлтгэл ажлыг хангах зорилготой.

Судалгааны ажлын арга зүй

Төсөл хэрэгжсэн 3 сургууль, цэцэрлэгийн нийт 6868 хүүхэд, эцэг эхчүүд, багш ажилчдаас түүвэрлэн тоон судалгаа авсан байна. Мөн төсөл хэрэгжсэн болон хэрэгжих 9 сургууль, цэцэрлэгийн удирдлага, холбогдох албан тушаалтнуудаас шаардлагатай тоон мэдээллийг цуглуулж, фото зургаар баталгаажуулсан байна.

Судалгааны ажлын үр дүн

**Нийгэм:** Хүүхдүүд, багш ажилчдын сурч, ажиллах орчин нөхцөл сайжирч, сэтгэл хангалуун байдал нэмэгдсэн. Мөн идэвх санаачилга нэмэгдэж, сурлага ажлын үр дүн сайжирсан байна.

**Эдийн засаг:** Засвар шинэчлэлтийн ажил хийгдсэнээр өвчлөлөөс шалтгаалан ажлаас чөлөө авах хоногийн тоо дунджаар 18 хувиар буюу 1 өдрөөр буурч, 1 өдрийн цалингийн орлого нэмэгдсэн байна. **Эрүүл мэнд:** Хүүхдүүд, багш, ажилчдын сургуулийн орчноос шалтгаалах өвчлөл 55 хувиар буурсан байна.

## 1.2. Олон улсад судлагдсан байдал

### ОЛОН УЛСАД ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАНГУУД

The collage contains several key documents:

- Sustainability Article:** "Influence of Air Temperature on School Teachers' Mood and the Perception of Students' Behavior" by Salvador Bello-Vieira, Elena Sala-Clar, Eva Isidro-Zamora, and Miguel Angel Serrano. It discusses how indoor air temperature affects teacher mood and student behavior.
- OECD Report:** "OECD Framework for a Model on the Physical Learning Environment - Revised Edition". It provides a framework for creating effective learning environments.
- School Building Assessment Methods:** A document by Henry Sanoff, AIA, Celen Pasalar, and Mine Hasnas, detailing methods for assessing school buildings.
- Classroom-Pupil Survey:** A form titled "Comfort in classroom-pupil survey" from Southampton School of Engineering, used to gather feedback from students on classroom comfort.

## Олон улсын судалгааны ажил

### Хүснэгт 2. Олон улсад судлагдсан байдлын хураангуй


Судлаач №1	OECD
Судалгааны ажлын нэр, он	<i>Learning Environments Evaluation Programme, /LEEP/, 2017</i>
Судалгааны ажлын зорилго	<i>Суралцах орчны үнэлгээний хөтөлбөр (LEEP) дамжуулан сургалтын орчин нь 21-р зууны сурагчид оюутнуудын чадварыг хөгжүүлэхэд шаардлагатай сурган хүмүүжүүлэх арга зүй, үнэлгээ болон зохион байгуулалтын хэлбэрийг хэрхэн үр дүнтэй дэмжих боломжтой вэ гэдгийг харах зорилготой юм. Иймээс LEEP нь хэмжих хэрэгсэл болон анализыг бий болгож, тэр нь сургуулийн удирдлага, судлаачид, бодлого гаргагчид болон бусад хүмүүст боловсролын орон зай ба янз бүрийн технологи зэрэг сургалтын, эрүүл мэндийн, нийгмийн болон сайн сайхны үр дүнг сайжруулж, энэ нь боловсролын нөөцийг хэрхэн илүү үр ашигтай ашиглахад хүргэж байгааг мэдээлэлдэг байна.</i>

Сургуулийн орчныг сайжруулж, дулаан алдагдлыг бууруулснаар сурагчид, тэдгээрийн эцэг эх, багш ажилчдын нийгэм, эдийн засаг, эрүүл мэндэд хэрхэн нөлөөлсөн талаарх суурь судалгаа хийлгэсэн байна. Судлаач нар сургуулийн орчин нь хүүхдэд хэрхэн нөлөөлдөг талаар олон судалгааны ажлуудыг хийж, олон төрлийн арга зүйг боловсруулжээ. Сургууль дулаан алдагдалтай байх нь сурагчдын сурлагын идэвх, эрүүл мэндэд сөргөөр нөлөө үзүүлэх; илүү их эрчим хүч зарцуулах; үүнээс үүдэн тухайн улсын


эдийн засгийн өрсөлдөх хүч буурах сөрөг үр дагавартай байна. Олон улсын болон дотоодод хийгдсэн судалгаануудыг уншиж судалснаар бид дараах аргачлалыг зураглалаа. Үүнд, дулаан техникийн засварын ажил нь сургуулийн орчны үнэлгээнд хэрхэн нөлөөлсөн, улмаар сурагч болон эцэг эх, багш нарын сэтгэлзүй хандлага болон сурлага, ажлын бүтээмжид хэрхэн нөлөөлж байгааг хэмжихээр загварчилсан.



Схем 1: Судалгааны загвар



## БҮЛЭГ 2: СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## II. Судалгааны аргачлал, мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт

### 2.1. Судалгааны аргачлал

“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь” үнэлгээний судалгааг дараах гурван судалгааны арга зүйг ашиглан хийж гүйцэтгэлээ. Үүнд:

а. Хоёрдогч мэдээллийн шинжилгээ: Олон улсад болон дотоодод судлагдсан байдал болон үнэлгээний загвар, аргачлалыг судлав. Мөн нээлттэй эх сурвалжууд дахь өрхийн эдийн засгийн статистик мэдээллүүд дээр анализ хийв.

б. Чанарын судалгаа: Сургууль, цэцэрлэгийн удирдлагатай чанарын судалгааны аргачлалын дагуу гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн. Тус ярилцлагын хүрээнд төсөл хэрэгжсэнээр гарсан өөрчлөлт, тулгамдаж буй асуудал, бэрхшээл, сайжруулах боломж, өнөөгийн нөхцөл байдлын талаар нарийвчлан судалсан. Мөн чанарын судалгааг төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургуулийн 7-12 дугаар ангийн сурагчид болон эцэг, эхтэй онлайн фокус бүлгийн ярилцлагын аргыг ашиглан хийж гүйцэтгэсэн.

с. Тоон судалгаа: Тоон судалгааг төсөлд хамрагдсан 5 сургуулийн 7-12 дугаар ангийн сурагчид мөн төсөлд хамрагдаагүй 2 сургуулийн 7-12 дугаар ангийн сурагчид болон 1-6 дугаар ангийн сурагчдын эцэг, эхчүүдийг хамруулан хийж гүйцэтгэсэн. Тоон судалгааны

мэдээлэл цуглуулалтыг хийхдээ таблет ашиглан нүүр тулсан ярилцлагын аргаар /CAPI/ сургуулийн орчинд судалгаа авсан.

### 2.2. Судалгааны хамрах хүрээ

“Монгол дахь барилга

Зураг 1. Таблет ашиглан судалгаа авах процесс



байгууламжийн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд хамрагдсан 18 сургууль, цэцэрлэг, төсөлд хамрагдаагүй 3 сургуулийн суралцагчид болон эцэг эхчүүд, багш, удирдлагаас тоон судалгаа авч нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөлөөллийг үнэлнэ.

Зураг 2. Судалгааны хамрах хүрээ, тоогоор



### Тоон судалгааны түүвэрлэлт, сургууль цэцэрлэг бүрээр

“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд СХД-т 11 сургууль,

цэцэрлэг; БЗД-т 7 сургууль, цэцэрлэг; НД-т 1 цэцэрлэгийн барилгын дулаан техникийн засвар хийжээ.

**Зураг 3 Төсөл хамрагдсан сургууль цэцэрлэгийн нийлбэр тоо, дүүргээр**



БЗД-т байрлалтай 3 сургууль, 4 цэцэрлэгийн барилгын дулаан техникийг засварлажээ.

**Зураг 4. БЗД-ээс төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэг**

БЗД-ийн 53-р сургууль	53
БЗД-ийн 55-р сургууль	41
БЗД-ийн 88-р сургууль	38
БЗД-ийн 115-р цэцэрлэг	30
БЗД-ийн 147-р цэцэрлэг	30
БЗД-ийн 62-р цэцэрлэг	20
БЗД-ийн 63-р цэцэрлэг	15

СХД-т байрлалтай 2 сургууль, 9 цэцэрлэгийн барилгын дулаан техникийг засварлажээ.

**Зураг 5 СХД-ээс төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэг**

СХД-ийн 74-р сургууль	39
СХД-ийн 65-р сургууль	53
СХД-ийн 127-р цэцэрлэг	22
СХД-ийн 148-р цэцэрлэг	12
СХД-ийн 158-р цэцэрлэг	16
СХД-ийн 79-р цэцэрлэг	12
СХД-ийн 80-р цэцэрлэг	21
СХД-ийн 81-р цэцэрлэг	16
СХД-ийн 90-р цэцэрлэг	10
СХД-ийн 91-р цэцэрлэг	24

Бид төсөлд хамрагдаагүй сургууль цэцэрлэгийг сонгохдоо төсөлд хамрагдсан сургууль цэцэрлэгүүдтэй байршил, хүүхдийн тоо, ашиглалтад орсон он зэргийн хувьд ойролцоо нөхцөл бүхий сургууль цэцэрлэгүүдийг сонгосон. Тухайлбал: БЗД-н Амгалан цогцолбор сургууль, 32 дугаар цэцэрлэг, СХД-н 42 дугаар сургууль, 84 дүгээр цэцэрлэгийг сонгож тус сургуулиудын сурагчид, тэдгээрийн эцэг эхчүүд, багш ажилчдыг судалгаанд хамрууллаа.

**Зураг 6. Төсөлд хамрагдаагүй сургууль, цэцэрлэг**

БЗД-ийн Амгалан цогцолбор	54
СХД-ийн 42-р сургууль	54
СХД-ийн 84-р цэцэрлэг	32
БЗД-ийн 32-р цэцэрлэг	52

### 2.3. Мэдээлэл цуглуулалт болон хэрэгжилт

Судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэхийн тулд дараах ажлуудыг шат дараатайгаар төлөвлөн хэрэгжүүлсэн. Үүнд:

- Судалгааны мэдээлэл цуглуулалтын бэлтгэл ажлыг хангах
- Судалгааны мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулах



- c. Мэдээлэл цуглуулалтын чанарт хяналт тавих
- d. Мэдээллийн сан үүсгэх
- e. Судалгааны үр дүнгийн тайлан боловсруулах

Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа бүрийг дэд бүлгүүдээр дэлгэрүүлэн авч үзье.

### 2.3.1. Судалгааны бэлтгэл ажлыг хангасан байдал

Бэлтгэл ажлын хүрээнд мэдээлэл оруулах программ бэлдэх, ярилцлага авагчдыг сургах, ажлуудыг хийж гүйцэтгэв.

- a. Мэдээлэл оруулах программ бэлдэх: Судалгааны мэдээлэл цуглуулах ажилд АНУ-ын Тооллогын товчооны боловсруулан гаргасан CSPPro программын 7.7 хувилбарыг ашигласан. Цэцэрлэгийн болон 1-6 дугаар ангийн сурагчдын эцэг эхийг хамруулах тоон судалгааны асуулга, 7-12 дугаар сурагчдыг хамруулах тоон судалгааны асуулга, багш нарыг хамруулсан тоон судалгааны асуулга тус бүрд мэдээлэл оруулах программыг бэлтгэсэн болно.
- b. Мэдээлэл цуглуулалтын багийн хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт: Судалгааны мэдээлэл цуглуулалтад ажиллах ярилцлага авагч нарыг сургаж, дадлагажуулах сургалтыг 2022 оны 2 сарын 25-ны өдөр 20 судлаачийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан. Ярилцлага авагч бүр тухайн судалгааны ажлын зорилго, ач холбогдол, мэдээлэл цуглуулалтын зохион

байгуулалт, асуулга дахь нэр томъёо, асуулгыг хэрхэн бөглөх талаар сайтар ойлголттой байх нь судалгааны үр дүнд чухал ач холбогдолтой. Иймээс судалгааны багийн удирдагч, судалгааны менежер, мэдээлэл цуглуулах баг, мэдээлэл цуглуулалтын хяналтын ажилчдыг хамруулсан сургалт зохион байгуулсан.

Сургалтыг дараах агуулгын хүрээнд зохион байгуулав. Үүнд:

- a. Төслийн танилцуулга
- b. Судалгааны зорилго, ач холбогдол
- c. Судалгааны аргачлал, зохион байгуулалт
- d. Судалгааны асуулгын танилцуулга
- e. Судлаачдын аюулгүй ажиллагааны заавар, зөвлөмж

Зураг 7. Сургалтын үйл ажиллагаа



### Зураг 8. Бэлтгэсэн программын харагдах байдал

Сайн байна уу? Намайг “.....” гэдэг. Би “Эм Эм Си Жи” үндэсний судалгааны компаниас явж байна. Бид энэ удаад “**Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь**” төсөлд хамрагдсан 18 сургууль, цэцэрлэгийн болон хамрагдаагүй 4 сургууль цэцэрлэгийн дулаан техникийн засвар шинэчлэлтийн ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

**ЯРИЛЦАГА ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:** Ярилцлага ойролцоогоор 15 минут орчим үргэлжилнэ. Таны хариултыг зөв, буруу гэж шүүхгүй учир та санаа зоволгүйгээр чөлөөтэй ярилцаарай.

**БАТЛАМЖ:** Таны зөвшөөрөлгүйгээр таныг таних ямар нэгэн мэдээллийг тайландаа оруулахгүй гэдгийг “Хувь хүний нууцын тухай Монгол Улсын хууль”-ийн 5 дугаар зүйлийн 4-т заасны дагуу баталж байна.

**СУДЛААЧИЙН КОДЫГ ТЭМДЭГЛЭХ**

### 2.4. Мэдээлэл цуглуулалтын зохион байгуулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2022 оны 2 дугаар сарын 28-аас 3 дугаар сарын 14 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ. Судалгааны мэдээлэл цуглуулалтын зохион байгуулахдаа урьдчилан сургууль, цэцэрлэгийн удирдлагууд руу судалгаа авах тухай албан бичиг хүргүүлж мэдэгдсэн.

Ярилцлага нар зорилтот төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй сургууль, цэцэрлэг дээр очиж сургуулийн орчинд багш, сурагчид, эцэг эхчүүдтэй нүүр тулсан ярилцлагын аргаар судалгааны мэдээллийг цуглуулсан.

### 2.5. Мэдээлэл цуглуулалтын чанарын хяналт

Мэдээлэл цуглуулалтын чанарыг шалгах ажлыг дараах 2 төрлөөр зохион байгууллаа. Үүнд:

**а. Ярилцлага авагч нар өөрсдийн ажилдаа хийх чанарын хяналт:** Судлаач нар ярилцлага бүрийн төгсгөлд асуулгыг бүрэн зөв бөглөсөн эсэхийг ярилцлага дууссан даруйд нь шалгасан. Түүнчлэн

ярилцлага авагч нар мэдээлэл цуглуулалтын хяналтын ажилтанд судалгааны өгөгдлөө хүлээлгэн өгөхийн өмнө өгөгдлийг хянаж, үг, үсгийн болон логикийн алдааг дахин хянасан.

**б. Мэдээлэл цуглуулалтын хяналтын багийн чанарын хяналт:**

Мэдээлэл цуглуулалтын хяналтын ажилтан ярилцлага авагч нараас өгөгдлийг хүлээн авч, асуулгыг бүрэн алдаагүй бөглөсөн эсэхийг шалгасан. Ярилцлага авагч нарын судалгааны асуулгыг үнэн зөв, судалгаанд оролцогчид ойлгомжтой асууж байгаа эсэхийг шалгах зорилгоор ярилцлагын явцад дуу хураагуур ажиллуулан хийсэн бичлэгүүдийг хяналтын ажилтнууд түүвэрлэн сонсож шаардлага хангаагүй судалгаануудыг өгөгдлөөс устгасан.

**с. Судалгааны мэдээлэл цуглуулалтын байдалд эргэн хяналт тавих (Back-checking):**

Судалгааны хяналтын багийн ахлагчид судлаачдын тухайн өдөр авсан судалгаа бүрээс түүвэрлэн судалгаанд оролцогчид руу залгаж зарим зүйлүүдийг тодруулдаг.

*Мэдээлэл цуглуулалтын чанарт хяналт тавихдаа бид ISO 20252:2019 стандартыг мөрдлөг болгон ажилладаг.*

Мэдээлэл цуглуулалтын чанарын хяналтын явцад ярилцлага авагч нар ямарваа нэг алдаа гаргах зэрэгт алдааны протокол хөтөлж, ярилцлага авагч нарт шаардлага тавин ажиллав.

## 2.6. Мэдээллийн сан үүсгэх, тайлан боловсруулалт

Судалгааны мэдээллийн санг Америкийн Тооллогын Товчооноос хөгжүүлсэн CSPro программын сүүлийн шинэчилсэн хувилбарыг ашиглаж үүсгэсэн. Тоон судалгааны өгөгдлийг IBM SPSS Statistics 25 программ руу хөрвүүлж судалгааны тайланд шаардлагатай үр дүнгүүдийг бэлтгэсэн.

**Зураг 9. SPSS датаны харагдах байдал**

DUUREG	S2_SURGUULIN_NER	S3_ANGI	S4
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 147-р цэцэрлэг	Ахлах бүлэг	Ээж
Сонгинохайрха...	СХД-ийн 80-р цэцэрлэг	Дунд бүлэг	Ээж
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 147-р цэцэрлэг	Дунд бүлэг	Ээж
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 32-р цэцэрлэг /Төсөлд хамрагдаагүй	Дунд бүлэг	Ээж
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 63-р цэцэрлэг	Бэлтгэл бүлэг	Ээж
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 115-р цэцэрлэг	Дунд бүлэг	Ээж
Сонгинохайрха...	СХД-ийн 84-р цэцэрлэг /Төсөлд хамрагдаагүй/	Ахлах бүлэг	Ээж
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 53-р сургууль	5-р анги	Аав
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 115-р цэцэрлэг	Бэлтгэл бүлэг	Аав
Сонгинохайрха...	СХД-ийн 127-р цэцэрлэг	Бэлтгэл бүлэг	Аав
Сонгинохайрха...	СХД-ийн 80-р цэцэрлэг	Ахлах бүлэг	Ээж
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 32-р цэцэрлэг /Төсөлд хамрагдаагүй	Бэлтгэл бүлэг	Ээж
Сонгинохайрха...	СХД-ийн 90-р цэцэрлэг	Ахлах бүлэг	Аав
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 62-р цэцэрлэг	Ахлах бүлэг	Ээж
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 55-р сургууль	6-р анги	Аав
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 62-р цэцэрлэг	Дунд бүлэг	Ээж
Сонгинохайрха...	СХД-ийн 80-р цэцэрлэг	Бага бүлэг	Ээж
Сонгинохайрха...	СХД-ийн 81-р цэцэрлэг	Дунд бүлэг	Ээж
Баянзүрх дүүрэг	БЗД-ийн 62-р цэцэрлэг	Бага бүлэг	Аав



2512,52	2512,52	2513	28%	703,04
2703,14	2703,14	2703	37%	1000,11
2803,32	2803,32	2803	15%	420,45
2926,21	2926,21	2926	15%	438,90
2850,07	2850,07	2850	32%	912,00
2822,23	2822,23	2822	37%	1044,14
2819,34	2819,34	2819	22%	648,37
2512,52	2512,52	2513		03,64
2703,14	2703,14	2703		0,11
2803,32	2803,32	2803		45
2926,21	2926,21	2926		90
2850,07	2850,07	2850		00
2822,23	2822,23	2822		14,14

## БҮЛЭГ 3: СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ДУЛААН ТЕХНИКИЙН ИХ ЗАСВАР





### **III. Сургууль, цэцэрлэгийн дулаан техникийн их засварын ажлын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд**

#### **3.1. Сургууль, цэцэрлэгийн их засварын хөрөнгө оруулалтын бүртгэлийн систем**

Швейцарын хөгжлийн агентлаг, ХБНГУ-ын Холбооны эдийн засаг, хөгжлийн яамны санхүүжилтээр Нийслэлийн засаг даргын тамгын газар, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ээс хамтран хэрэгжүүлж буй “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөл нь дулаан алдагдлыг багасгаж, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх зорилгын хүрээнд 2018-2021 онд Нийслэлийн 13 цэцэрлэг, 5 сургуульд дулаан, техникийн засвар шинэчлэлтийн ажил хийгдсэн. Уг ажлын хүрээнд төсвийн болон гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар нийслэлд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй боловсролын салбарын их засварын цахим бүртгэлийн системийн талаар ямар сэтгэгдэлтэй байгааг сургууль, цэцэрлэгийн удирдлагуудаас тодрууллаа. Ингэхэд сургууль, цэцэрлэгийн удирдлагууд уг цахим системийг тун үр өгөөжтэй ажил болсон гэж үнэлж байна. Тухайлбал, хэрэглэхэд хялбар, ойлгомжтой, тэгш хүртээмжийг олгосон, ил тод нээлттэй, цэгцтэй, шударга үнэлгээний аргачлал болсон гэж үзэж байна. Сайжруулах саналд сургууль, цэцэрлэгийн бүх асуудлыг цогцоор нь шийдвэрлэх тал дээр учир дутагдалтай байгаа тухай дурдаж байна. Жишээлбэл, дулаалгын засварын ажил хийгдсэн ч сантехник, агааржуулалтын систем, цахилгааны асуудлаа шийдвэрлэж чадаагүй

сургууль, цэцэрлэгүүд олон байна. Энэ нь төсөв мөнгийг олон цэцэрлэг, сургуульд хуваарилах зорилгоор нэг сургууль, цэцэрлэгүүдэд бага багаар санхүүжилт олгож байгаа холбоотой болов уу гэж тайлбарлаж байна.

Мөн хөрөнгө оруулалтын шийдвэр хэрхэн гарсан тухай мэдээллийг буцаж мэдээлэх, эргэх холбоотой ажиллах тал дээр илүү сайжруулах хэрэгтэй гэсэн санал гарлаа.

#### **3.2. Удирдлага, багш, эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ**

Цэцэрлэг, сургуулийн барилга, байгууламжийн их засварын ажлын гүйцэтгэлд удирдлага, багш, эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд “Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ”-ний ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Уг хяналт-шинжилгээ, үнэлгээ нь их засварын ажилд хэрхэн нөлөөлсөн талаар сургууль, цэцэрлэгийн удирдлагуудаас тодруулав. Төсөл хэрэгжсэн сургууль, цэцэрлэгүүдэд эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний “Хяналтын баг”-ийн идэвх, зохион байгуулалт нь барилгын их засварын ажил үр дүнтэй хэрэгжиж дуусахад илэрхий нөлөөлсөн байгаа нь ярилцлагаас ажиглагдаж байна. Тухайлбал, хяналтын баг барилгын ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж, гүйцэтгэгч байгууллагад шаардлага тавьж идэвхтэй ажилласнаар барилгын их засварын ажил ямарваа нэгэн асуудал багатай дуусаж байна. Барилгын их засварын ажилд асуудал тулгарвал тухай бүрд нь сануулах, санал хүсэлтээ холбогдох газарт нь мэдэгдэж асуудлыг

шийдвэрлүүлснээр төслийн үр дүнг нэмэгдүүлжээ. Жишээлбэл, эцэг эх болон багш нарын хамтарсан баг барилгын материалын чанар, сонголт зэрэгт хяналт хийж ашиглалтын инженертэй хамтран ажилласнаар барилгын засварын гүйцэтгэл чанартай хийгдэхэд нөлөөлж чадсан гэж үзэж байна. Зарим хамтарсан багууд хяналтын хуваарь гарган сар болгон багийн гишүүдэд тайлан танилцуулах байдлаар ажиллажээ. Гэтэл зарим сургууль, цэцэрлэгийн эцэг эх барилгын ажил зуны улиралд хэрэгжсэн тул хангалттай сайн хяналт тавьж чадаагүй байна.

### 3.3. Засвар, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэл

Төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн барилгын засварын ажлын чанарт эцэг эхийн оролцоо, хяналт-шинжилгээ, үнэлгээнээс гадна гүйцэтгэгч байгууллага, хөрөнгө оруулалтын хэмжээ зэрэг өөр бусад хүчин зүйлс нөлөөлж байна.

Чанартай хийгдсэн ажлууд буюу сэтгэл ханамжтай ажлуудад:

- Гадна фасад;
- Цонхны дулаалга /Вакум цонх/;
- Сантехник, дулааны шугам;
- Шал, хундамын дулаалга гэх мэт хийгдсэн ажлуудад ерөнхийдөө сэтгэл ханамж өндөр байна.

Чанаргүй хийгдсэн ажлуудад гүйцэтгэгч байгууллагаас хамаарах хүчин зүйлс түлхүү орж байна. Жишээлбэл:

- Дээврийн засварын ажил хангалтгүй;
- Цонхны амлагаа зөрсөн, хэмжээ алдагдалтай;
- Дотоод заслын ажил хангалтгүй;

- Барилгын засварын ажил хугацаандаа дуусаагүй;
- Гүйцэтгэгч байгууллагын хүн хүч дутмаг, мэргэжлийн бус /Барилгын ажлын явцад гэрээт ажилтан хайх, ажилтнууд согтууруулах ундаа хэрэглэсэн байх, мэргэжлийн бус хүн ажиллуулах гэх мэт/;
- Хангалттай төсөв мөнгөгүй, ингэснээр барилгын материалаа худалдан авах, цалингаа тавих зэрэгт асуудал тулгарах гэх мэт асуудлуудыг дурдаж байна.

Судалгаанд хамрагдсан удирдлагуудын зүгээс хамгийн түгээмэл хэлж буй санал нь гүйцэтгэгч байгууллагын чанарыг сайжруулах, тендер шалгаруулалтыг илүү сайжруулах, гүйцэтгэгч байгууллагууд нэг чанарын стандарттай болохыг хүсэж байна.

### 3.4. Төсөл хэрэгжсэн дүүргүүдийн тоон үзүүлэлт<sup>1</sup>

“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд БЗД, СХД, Налайх дүүрэгт нийт 18 цэцэрлэг, сургуулиудад барилгын засварын ажил хийгдсэн байна. эдгээр дүүргүүдийн суурь нөхцөл байдлыг тоон үзүүлэлтүүдээр харуулж байна.

БЗД, СХД нь Улаанбаатар хотын хамгийн их хүн амтай буюу нийт хүн амын 47.1 хувь, нийт өрхийн 48.2 хувь оршин сууж байна. Эдгээр дүүргүүдэд төрөлтийн тоо 46.7 хувийг эзэлж байна. Налайх дүүрэгт нийт хүн ам, өрхийн 2.5 хувь бүртгэлтэй байна. Эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтүүдэд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 39 хувь, халдварт өвчнөөр өвчлөгчдийн 42 хувийг БЗД, СХД, Налайх дүүрэг эзэлж байна. Боловсролын салбарын үзүүлэлтүүдэд СӨБ -д суралцагчдын тооны 46.7 хувь, ЕБС-д суралцагчдын 44.8 хувийг эдгээр 3 дүүрэг эзэлж байна.

Агаарын бохирдлын түвшнээр СХД орчим бүс нутаг хамгийн их бохирдолтой буюу Нүүрстөрөгчийн дутуу исэл СО -ын 2017-2022 оны хоёр дугаар сарын дундаж хэмжээ 3.58, тоос РМ 2.5 -ийн дундаж хэмжээ 0.12 ([Хавсралт](#)) байна.

Хүн амын тоо, эрүүл мэндийн үзүүлэлт, боловсрол, агаарын чанарын үзүүлэлтүүдээр БЗД, СХД нь хамгийн өндөр байгаа бөгөөд уг төсөл нь

нийслэлийн хүн амын 50 орчим хувьд хүрч байна.

Төсөл хэрэгжсэн дүүргүүдийн статистик мэдээлэл /БЗД, СХД, НД/

ХҮН АМ ЗҮЙН СТАТИСТИК

**764,361** (49.6%)

Өрхийн тоо, 2020

**210,311** (50.7%)

Төрөлтийн тоо, 2021

**16,661** (49.3%)

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИК

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 2020

**206** (39.0%)

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, 2020

**7,986** (42.0%)

БОЛОВСРОЛЫН СТАТИСТИК

СӨБ-д суралцагчдын тоо, 2021-2022

**52,115** (46.7%)

ЕБС-д суралцагчдын тоо, 2021-2022

**142,804**

% - (Нийслэлийн дүнд эзлэх хувь)

<sup>1</sup> УСХ, [www.1212.mn](http://www.1212.mn)

Төсөл хэрэгжсэн 18 сургууль, цэцэрлэгүүдийн хамран сургах тойргийн статистикуудыг харуулж байна. Төсөл хэрэгжсэн СӨБ-ийн хамран сургах тойрогт 66,285 өрх (нийслэлийн нийт өрхийн 16.0%), 0-5 насны 23,347 хүүхэд оршин сууж байна. Төсөлд хамрагдсан цэцэрлэгийн нийт суралцагчдын тоо 2020-2021 оны хичээлийн жилд<sup>2</sup> 5,477 бөгөөд энэ нь нийслэлийн нийт цэцэрлэгийн хүүхдийн 4.9 хувийг эзэлж байна. Төсөлд хамрагдсан цэцэрлэгийн нийт ажиллагчдын тоо 1,012 байна.

Төсөлд хамрагдсан 5 сургуулийн хамран сургах тойргийн статистикийн хувьд 36,089 өрх (нийслэлийн нийт өрхийн 8.7%), 6-18 насны 28,117 хүүхэд амьдарч байна. Төсөлд хамрагдсан 5 сургуулийн нийт суралцагчдын тоо 2020-2021 оны хичээлийн жилд<sup>3</sup> 9,000 байсан бөгөөд 2021-2022 оны хичээлийн жилд энэ тоо өссөн дүнтэй байгаа.

Төсөл хэрэгжсэн дүүргүүдийн хамран сургах тойргийн статистик мэдээлэл /БЗД, СХД, НД/

#### СӨБ-ИЙН СТАТИСТИК

Өрхийн тоо, 2020

**66,285** (16.0%)

0-5 насны хүүхдийн тоо, 2021

**23,347**

Төсөлд хамрагдсан цэцэрлэгийн нийт суралцагчдын тоо, 2020-2021

**5,477** (4.9%)

Төсөлд хамрагдсан цэцэрлэгийн нийт ажиллагчдын тоо, 2020-2021

**1,012**

#### ЕБС-ИЙН СТАТИСТИК

Өрхийн тоо, 2020

**36,089** (8.7%)

6-18 насны хүүхдийн тоо, 2021

**28,117**

Төсөлд хамрагдсан сургуулийн нийт суралцагчдын тоо, 2020-2021

**9,000** (2.8%)

Төсөлд хамрагдсан цэцэрлэгийн нийт ажиллагчдын тоо, 2020-2021

**418**

% - (Нийслэлийн дүнд эзлэх хувь)

<sup>2</sup> БШУЯ, СӨБ-ийн статистик, 2020-2021

<sup>3</sup> БШУЯ, ЕБС-ийн статистик, 2020-2021





## БҮЛЭГ 4. ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН

#### IV. Хамаарлын шинжилгээний үр дүн

Судалгааны хүрээнд хүчин зүйлсийн хамаарлын шинжилгээгээр судалгааны үнэлгээний үзүүлэлтүүдийг дараах бүлэг хувьсагчуудад ангилж байна. Уг ангиллыг Scale Reliability test, Factor analysis дээр суурилан хийж гүйцэтгэсэн болно. Бүлэг хувьсагч тус бүрд хамаарч буй шалгуур үзүүлэлтүүдийг доор харуулж байна.

*Хүснэгт 3: Үнэлгээний хувьсагчид, түүнд хамаарах үзүүлэлтүүд*

Дотоод орчны сэтгэл ханамж (Indoor Environment Satisfaction)	Pearson Correlation
Cronbach's Alpha <sup>4</sup>	0.871
1. Орчны тав тух	77%
2. Ариун цэврийн өрөө	73%
3. Зай талбай	70%
4. Агаарын чанар	70%
5. Гэрэлтүүлэг	67%
6. Орчны температур, өвлийн улиралд	66%
7. Анги танхимын доторх тохижилт	65%
8. Орчны температур, яг одоо	61%
9. Доторх дуу чимээ	61%
10. Орчны температур, зуны улиралд	59%
Сурлагын идэвх (Performance)	Pearson Correlation
Cronbach's Alpha	0.737
1. Анхаарал төвлөрөх байдал	84%
2. Сурлагын дүн	83%
3. Хичээлдээ сонирхолтой, дуртай байдал	76%
Зан төлөв, сэтгэл зүй (Behaviour)	Pearson Correlation
Cronbach's Alpha	0.723
1. Сэтгэл санааны байдал /стресс/	76%
2. Ядаргаанд орох байдал	75%
3. Өөртөө итгэлтэй байдал	63%

4. Хүүхдүүд, багш нартай харилцах байдал	55%
5. Эрүүл мэндийн байдал	50%
6. Сургуулийн орчноос ичих байдал	49%
7. Сургууль, цэцэрлэг дээрээ аюулгүй санагдах байдал	48%
8. Гэр бүлийн гишүүдтэй харилцах байдал	43%
Эцэг эхийн анхаарал, халамж (Parents_attention)	Pearson Correlation
Cronbach's Alpha	0.73
1. Хүүхдийн эрүүл мэндэд	69%
2. Хүүхдийн сэтгэл санааны байдалд	77%
3. Хүүхдийн сурлага, хичээлийн дүнд	77%
4. Сургуулийн үйл ажиллагаанд оролцох байдал	76%

Дотоод орчны үзүүлэлтүүдээс орчны тав тух, ариун цэврийн өрөө, зай талбай, агаарын чанар, гэрэлтүүлэг, агаарын хэм зэрэг үзүүлэлтүүд өндөр нөлөөтэй байна.

Сурлагын идэвхийн шалгуур үзүүлэлтүүдэд хүүхдийн анхаарал төвлөрөх байдал, сурлагын дүн, хичээлдээ дуртай байдал багтаж байна. Зан төлөв, эрүүл мэндэд стресс, ядаргаа, өөртөө итгэлтэй байдал, бусадтай харилцах байдал, эрүүл мэндийн байдал илүү өндөр нөлөөтэй байна.

Дээрх бүлэг хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээг SmartPLS-SEM model ашиглан үнэлсэн. Үүний үр дүнг дараах дэд бүлгүүдэд танилцуулж байна.

<sup>4</sup> Cronbach' Alpha – 0.70-оос дээш байх ёстой

#### 4.1. Цэцэрлэгийн хүүхдэд үзүүлсэн нөлөө

Цэцэрлэгийн дулаан техникийн засварын ажил хийгдсэнээр цэцэрлэгийн орчин, хүүхдийн сэтгэл зүй, зан төлөв, сурлага, эцэг эхийн оролцоо зэрэгт хэрхэн нөлөөлснийг SmarPLS-SEM model ашиглан үнэллээ. Ингэхэд шууд болон шууд бус хамаарал илэрснийг дараах хүснэгтэд танилцуулж байна.

##### 4.1.1. Дулаан техникийн засварын ажлын нөлөө

Дулаан техникийн засварын ажил хийгдсэнээр дотоод орчны сэтгэл ханамжид 37%, дотоод орчны температурт 36% -иар шууд нөлөө үзүүлжээ. Дулаан техникийн засварын ажил хийгдэж дотоод орчин нөхцөл 36-37 хувиар сайжирсан байна. Ингэснээр хүүхдийн сэтгэл зүй, өвчлөл, сурлага, эцэг эхийн хандлагад дам нөлөө үзүүлсэн байна. Тодруулбал, хүүхдийн сэтгэлзүй зан төлөвт 31%, өвчлөлд -14%, эцэг эхийн анхаарал, халамж 16%, сурагчийн сурлагын идэвхэд 20% -иар нөлөөлжээ. Дулаан техникийн засварын ажил болон дотоод орчны температурын дам нөлөөлөл адил хэмжээтэй байна.

*Зураг 10: Дулаан техникийн засварын ажлын шууд болон шууд бус нөлөө, цэцэрлэгийн орчинд*

##### 4.1.2. Дотоод орчны нөлөө

Дулаан техникийн засварын ажил хийгдсэнээр дотоод орчны температурын үнэлгээ 36 хувиар нь өссөн. Ингэснээр дотоод орчны үнэлгээ 56 хувиар өссөн. Дотоод орчны нөхцөл байдал сайжирснаар өвчлөл 26 хувиар буурчээ. Дотоод орчин сайжрах нь эцэг эхийн анхаарал халамж, эцэг эхийн оролцоог 28 хувиар нэмэгдүүлж байна.

##### 4.1.3. Сэтгэлзүй, зан төлөв ба сурлагын идэвх хоорондын хамаарал

Үнэлгээний загвараас харахад дотоод орчны нөхцөл байдал, өвчлөл, эцэг эхийн анхаарал халамж нь хүүхдийн сэтгэлзүйд шууд нөлөө үзүүлэх ба ингэснээр сурлагын идэвхэд дам нөлөө үзүүлж байна. Хүүхдийн сэтгэл зүй, зан төлөв нь сурлагын идэвх гэсэн үзүүлэлттэй 63 хувийн хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, хүүхдийн сурлагын идэвх, амжилтыг өндөр байлгахын тулд сэтгэл зүйг нь тайван тогтуун, өөдрөг, эерэг байлгах хэрэгтэй. Ингэхийн тулд орчны нөлөө хүчтэй байгаа нь үнэлгээний үр дүнгээс тодорхой харагдаж байна.

#### ДУЛААН ТЕХНИКИЙН ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ, ЦЭЦЭРЛЭГТ

##### ШУУД НӨЛӨӨ

Дотоод орчны температур

**+36%**

Дотоод орчны үнэлгээ

**+37%**

##### ДАМ НӨЛӨӨ

Зан төлөв, сэтгэл зүй

**+31%**

Өвчлөл

**-14%**

Сурлагын идэвхи

**+20%**

Эцэг эхийн анхаарал, халамж

**+16%**

**Хүснэгт 4: Дулаан техникийн засварын ажлын шууд нөлөө, цэцэрлэгийн орчинд**

ШУУД ХАМААРАЛ	Original Sample (O)	Standard Deviation (STDEV)	T Statistics ( O/STDEV )	P Values <sup>5</sup>
Thermo-Technical Refurbishment -> Class_Environment_Satisfaction	37%	5%	7.841	0.000
Thermo-Technical Refurbishment -> Inside Temperature	36%	5%	6.802	0.000
Inside Temperature -> Class_Environment_Satisfaction	56%	5%	11.628	0.000
Class_Environment_Satisfaction -> Illness	-26%	6%	4.187	0.000
Class_Environment_Satisfaction -> Parents Attention	28%	5%	5.367	0.000
Class_Environment_Satisfaction -> Behaviour	43%	6%	7.761	0.000
Illness -> Behaviour	-16%	5%	2.891	0.004
Parents Attention -> Behaviour	31%	6%	5.539	0.000
Behaviour -> Performance	63%	8%	8.195	0.000

**Хүснэгт 5: Дулаан техникийн засварын ажлын шууд бус нөлөө, цэцэрлэгийн орчинд**

ШУУД БУС ХАМААРАЛ	Original Sample (O)	Standard Deviation (STDEV)	T Statistics ( O/STDEV )	P Values
Thermo-Technical Refurbishment -> Behaviour	31%	4%	8.579	0.000
Thermo-Technical Refurbishment -> Performance	20%	3%	6.281	0.000
Thermo-Technical Refurbishment -> Illness	-14%	4%	3.701	0.000
Thermo-Technical Refurbishment -> Parents Attention	16%	3%	5.187	0.000
Class_Environment_Satisfaction -> Performance	35%	6%	6.121	0.000
Illness -> Performance	-10%	3%	3.058	0.002
Parents attention -> Performance	19%	4%	5.154	0.000
Inside temperature -> Behaviour	31%	5%	6.77	0.000
Inside temperature -> Illness	-14%	4%	4.058	0.000
Inside temperature -> Parents attention	16%	3%	4.541	0.000
Inside temperature -> Performance	19%	4%	4.532	0.000


**Нэр томъёоны тайлбар:**

- *Thermo technical refurbishment* - Дулаан техникийн засварын ажил
- *Class environment satisfaction* – Дотоод орчны сэтгэл ханамж
- *Behaviour* – Зан төлөв
- *Performance* – Сурлагын идэвх
- *Parents attention* – Эцэг эхийн анхаарал, халамж
- *Illness* – Өвчлөл
- *Inside temperature* – Дотоод орчны температур

<sup>5</sup> P value нь статистикийн хувьд хамааралтай эсэхийг хэмжих бөгөөд 0.05 -аас бага үед хамааралтай гэж үзнэ.



Схем 2. Дулаан техникийн засварын ажлын цэцэрлэгийн хүүхдэд үзүүлж буй нөлөө, SmartPLS, SEM model, шууд нөлөөний үр дүн



## 4.2. Сургуулийн хүүхдэд үзүүлсэн нөлөө

Дулаан техникийн засварын ажил нь сургуулийн сурагчийн сурлага, эрүүл мэнд, сэтгэл зүй, зан төлөвт хэрхэн нөлөөлж байгааг хэмжихэд цэцэрлэгийн хүүхдэд үзүүлсэн нөлөөнөөс харьцангуй бага байна. Мөн сургуулийн сурагчийн эцэг эхийн анхаарал, халамж, сурагчийн өвчлөлд төслийн нөлөө бага байна. Энэ нь мэдээлэл цуглуулалтын ажил хичээл эхэлснээс 7 хоногийн дараа эхэлсэнтэй холбоотой гэж таамаглаж байна. Өөрөөр хэлбэл, цэцэрлэгийн хүүхэдтэй харьцуулахад сургуулийн орчноос хамааралтай өвчлөл харьцангуй бага байна гэсэн таамаглал дэвшүүлж байна.

### 4.2.1. Дулаан техникийн засварын ажлын нөлөө

Төслийн шууд нөлөө үзүүлсэн үзүүлэлтүүдэд дотоод орчны температур, сурагчийн зан төлөв, сэтгэлзүйд шууд нөлөө үзүүлжээ. Тухайлбал, сургуулийн дотоод орчны температурын үнэлгээнд 25 хувиар нөлөөлжээ. Цэцэрлэгийн хүүхдийн сэтгэл зүйд дулаан техникийн засварын ажил нь дам байдлаар нөлөөлж байсан бол сургуулийн сурагчид 12 хувиар шууд нөлөө үзүүлсэн байна.

Дулаан техникийн засварын ажил нь сургуулийн орчинд дам байдлаар нөлөө үзүүлсэн хувьсагчдад сургуулийн орчны үнэлгээнд дотоод орчны температураар дамжуулан дам

байдлаар 13 хувиар нөлөөлжээ. Харин сурагчийн сурлагын идэвхэд дам байдлаар 4 хувиар нөлөө үзүүлсэн байна.

### 4.2.2. Дотоод орчны температур

Дотоод орчны температур нь сургуулийн орчны үнэлгээнд 52 хувиар шууд нөлөөлсөн бол сурагчийн зан төлөв хандлагад дам байдлаар 16 хувь, сурагчийн сурлагын идэвхэд дам байдлаар 4 хувийн нөлөө үзүүлжээ.

### 4.2.3. Дотоод орчны нөлөө

Төсөл хэрэгжсэнээр дотоод орчны үнэлгээнд шууд бусаар 13 хувийн нөлөө үзүүлсэн. Харин дотоод орчин нь сурагчийн зан төлөв, сэтгэл зүйд 31 хувийн шууд нөлөө үзүүлж байна. Харин сурлагын идэвхэд дам байдлаар 8 хувийн эерэг нөлөө үзүүлжээ.

### 4.2.4. Сэтгэлзүй, зан төлөв ба сурлагын идэвх хоорондын хамаарал

Сургуулийн сурагчдын хувьд сэтгэлзүй зан төлөв болон сурлагын идэвх хооронд 26 хувийн хамаарал байна. Энэ нь цэцэрлэгийн хүүхэдтэй харьцуулахад 3 дахин бага утга юм. Сэтгэлзүйд нөлөөлж буй үзүүлэлтээс орчны нөлөө нь эцэг эхийн анхаарал, халамжаас өндөр байна. Харин сурлагын амжилтад эцэг эхийн анхаарал, халамж, оролцоо харьцангуй өндөр буюу 33 хувийн хамааралтай байна.

Зураг 11: Дулаан техникийн засварын ажлын үзүүлсэн нөлөө, сургуульд

## ДУЛААН ТЕХНИКИЙН ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ, СУРАГЧИД

## ШУУД НӨЛӨӨ

Дотоод орчны температур

**+25%**

Сурагчийн сэтгэл зүй, зан төлөвт

**+12%**

## ШУУД БУС НӨЛӨӨ

Дотоод орчны үнэлгээ

**+13%**

Сурагчийн сурлагын идэвхи

**+4%**


Хүснэгт 6: Дулаан техникийн засварын ажлын шууд нөлөө, сургуулийн орчинд

Шууд хамаарал	Original Sample (O)	Sample Mean (M)	Standard Deviation (STDEV)	T Statistics ( O/STDEV )	P Values
Thermo-Technical Refurbishment -> Inside temperature	25%	26%	6%	4.663	<b>0.000</b>
Thermo-Technical Refurbishment -> Behaviour	12%	12%	6%	2.137	<b>0.033</b>
Inside temperature -> Class_Environment_Satisfaction	52%	52%	5%	10.006	<b>0.000</b>
Class_Environment_Satisfaction -> Behaviour	31%	31%	7%	4.234	<b>0.000</b>
Behaviour -> Performance	26%	26%	7%	3.864	<b>0.000</b>
Parents attention -> Performance	33%	32%	6%	5.094	<b>0.000</b>
Parents attention -> Behaviour	22%	22%	6%	3.959	<b>0.000</b>

Хүснэгт 7: Дулаан техникийн засварын ажлын дам шууд нөлөө, сургуулийн орчинд

Шууд бус хамаарал	Original Sample (O)	Sample Mean (M)	Standard Deviation (STDEV)	T Statistics ( O/STDEV )	P Values
Thermo-Technical Refurbishment -> Class_Environment_Satisfaction	13%	13%	3%	4.115	<b>0.000</b>
Thermo-Technical Refurbishment -> Performance	4%	4%	2%	2.185	<b>0.029</b>
Inside temperature -> Behaviour	16%	16%	4%	3.92	<b>0.000</b>
Inside temperature -> Performance	4%	4%	2%	2.341	<b>0.020</b>
Parents attention -> Performance	6%	6%	2%	3.134	<b>0.002</b>
Class_Environment_Satisfaction -> Performance	8%	8%	3%	2.298	<b>0.022</b>

Схем 3: Дулаан техникийн засварын ажил нь сургуулийн сурагчдад үзүүлж буй нөлөө, SmartPLS, SEM model, шууд нөлөөний үр дүн





### 4.3. Багш нарт үзүүлсэн нөлөө

Дотоод орчны температур нь багш нарын ажлын бүтээмжид хэрхэн нөлөөлж байгааг SmartPLS SEM загвар аргачлал ашиглан үнэллээ.

#### 4.3.1. Дулаан техникийн засварын ажлын нөлөө

Багш нарын үнэлгээнээс харахад дулаан техникийн засварын ажлын нөлөө нь дотоод орчны сэтгэл ханамжид 42 хувиар, дотоод орчны температурын үнэлгээнд 55 хувиар шууд нөлөөлжээ.

Харин багш нарын сэтгэл зүйд 25 хувиар багш нарын ажлын гүйцэтгэлд 14 хувиар дам нөлөө үзүүлсэн байна.

#### 4.3.2. Дотоод орчны температур

Дулаан техникийн засварын ажил хийгдсэнээр дотоод орчны температурын үнэлгээ өссөн. Харин дотоод орчин дулаан тав тухтай болсноор орчиндоо сэтгэл ханамжтай байдал 50 хувиар нэмэгдэж байна.

Орчны температур нэмэгдсэнээр багшийн сэтгэл зүйд 18 хувиар, багшийн ажлын бүтээмжид 10 хувиар эерэг дам нөлөө үзүүлжээ.

#### 4.3.3. Дотоод орчны нөлөө

Дотоод орчны үнэлгээнд дулаан техникийн засварын ажлын нөлөө харьцангуй өндөр байсан. Тэгвэл дотоод орчинд сэтгэл ханамж нэмэгдэхэд багшийн сэтгэл зүйд 36 хувиар дам нөлөөлж байна. Мөн багшийн ажлын бүтээмжид дотоод орчин 20 хувиар дам нөлөө үзүүлжээ.

#### 4.3.4. Сэтгэлзүй, зан төлөв болон багшийн ажлын бүтээмж хоорондын хамаарал

Багшийн сэтгэл зүй, зан төлөв болон ажлын бүтээмжийн хооронд 56 хувийн хамаарал байна. Дулаан техникийн засварын ажил болон дотоод орчны температур нь багшийн сэтгэл зүй, зан төлөвт эхэлж нөлөөлөн, улмаар ажлын бүтээмж, гүйцэтгэлд дам нөлөө үзүүлжээ.

## ДУЛААН ТЕХНИКИЙН ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ, БАГШИД

### ШУУД НӨЛӨӨ

Дотоод орчны температур

**+55%**

Дотоод орчны сэтгэл ханамж

**+42%**

### ШУУД БУС НӨЛӨӨ

Багшийн сэтгэл зүй

**+25%**

Багшийн ажлын гүйцэтгэл

**+14%**


Хүснэгт 8: Дулаан техникийн засварын ажлын багш нарт үзүүлж буй шууд нөлөө

ШУУД ХАМААРАЛ	Original Sample (O)	Standard Deviation (STDEV)	T Statistics ( O/STDEV)	P Values
Thermo-Technical Refurbishment -> Indoor Environment Satisfaction	42%	13%	3.176	0.002
Thermo-Technical Refurbishment -> Indoor Temperature	55%	11%	4.899	0.000
Indoor Environment Satisfaction -> Teacher mood	36%	12%	2.911	0.004
Indoor Temperature -> Indoor Environment Satisfaction	50%	11%	4.586	0.000
Teacher mood -> Teacher performance	56%	10%	5.863	0.000

Хүснэгт 9: Дулаан техникийн засварын ажлын багш нарт үзүүлж буй шууд бус нөлөө

ШУУД БУС ХАМААРАЛ	Original Sample (O)	Standard Deviation (STDEV)	T Statistics ( O/STDEV)	P Values
Thermo-Technical Refurbishment -> Teacher mood	25%	10%	2.616	0.009
Thermo-Technical Refurbishment -> Teacher performance	14%	7%	2.116	0.035
Indoor Environment Satisfaction -> Teacher performance	20%	9%	2.301	0.022
Indoor Temperature -> Teacher mood	18%	8%	2.325	0.020
Indoor Temperature -> Teacher performance	10%	5%	1.963	0.050

Схем 4: Дулаан техникийн засварын ажлын багш нарт үзүүлж буй нөлөө, SmartPLS, SEM model, шууд нөлөөний үр дүн



## V. Судалгааны дэлгэрэнгүй үр дүн

Энэ бүлэгт судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл, сургууль, цэцэрлэгийн дотоод орчны сэтгэл ханамжийн үнэлгээ, нийгмийн нөлөө, эдийн засгийн нөлөө гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ.

### 5.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Энэ бүлэгт судалгаанд оролцсон сурагчид, эцэг эх, багш нарын нас, хүйс, амьдардаг дүүрэг, өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл, өрхийн сарын дундаж орлого, сурагчид болон багш ажилчдын сургууль, цэцэрлэгт сурч, ажиллаж буй жил зэргийг нарийвчлан судалсан.

Судалгаанд төсөлд хамрагдсан болон хамрагдаагүй дараах сургууль, цэцэрлэгүүдийн суралцагчдын тооноос хамааруулан “Stratified sampling” буюу “Бүлэглэсэн түүвэрлэлт”-н аргаар түүвэрлэсэн ба сургууль бүрд хэрхэн тархаасныг дараах хүснэгт 3-с харна уу.


*Хүснэгт 10 Түүвэрт эзлэх хувь, сургуулиар*

Төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэг	Хувь
БЗД-ийн 53-р сургууль	17%
БЗД-ийн 55-р сургууль	3%
БЗД-ийн 88-р сургууль	3%
СХД-ийн 74-р сургууль	4%
СХД-ийн 65-р сургууль	23%
БЗД-ийн 115-р цэцэрлэг	4%
БЗД-ийн 147-р цэцэрлэг	4%
БЗД-ийн 62-р цэцэрлэг	3%
БЗД-ийн 63-р цэцэрлэг	2%
Налайх дүүргийн 152-р цэцэрлэг	2%
СХД-ийн 127-р цэцэрлэг	3%
СХД-ийн 148-р цэцэрлэг	2%
СХД-ийн 158-р цэцэрлэг	2%
СХД-ийн 79-р цэцэрлэг	2%
СХД-ийн 80-р цэцэрлэг	3%
СХД-ийн 81-р цэцэрлэг	2%
СХД-ийн 90-р цэцэрлэг	1%
СХД-ийн 91-р цэцэрлэг	3%

Төсөлд хамрагдаагүй сургууль, цэцэрлэг	Хувь
БЗД-ийн Амгалан цогцолбор	6%
СХД-ийн 42-р сургууль	7%
СХД-ийн 84-р цэцэрлэг	1%
БЗД-ийн 32-р цэцэрлэг	3%


Судалгаанд оролцогчдын 61 хувь нь эцэг, эх, асран хамгаалагч хамрагдсан бол 29 хувь нь 7-12 дугаар ангийн сурагчид, 9 хувь нь багш нар хамрагдсан. Нийт судалгаанд оролцсон сурагчдаас 52 хувь нь эрэгтэй, 48 хувь нь эмэгтэй байна.

*График 1. Судалгаанд хамрагдсан бүлгүүд, хүйсээр*



Судалгаанд хамрагдсан сурагчдын 35 хувь нь 7-8 дугаар анги, 34 хувь нь 11-12 дугаар анги, 31 хувь нь 9-10 дугаар ангийнхан хамрагдсан байна.

График 2. Судалгаанд хамрагдсан сурагчид, ангийн бүлгээр




Сурагчдын асран хамгаалагчдын 47 хувь нь 1-6 дугаар ангийн хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагчид хамрагдсан байна. Сурагчдын асран хамгаалагчдыг сонгож судалгаанд хамруулахдаа сургууль, цэцэрлэгийн өмнөх болон дараах орчны нөхцөл байдлыг харьцуулан үнэлгээ өгч чадахуйц байдлыг чухалчилсан.

График 3. Хүүхдүүдийн асран хамгаалагч, аав, ээж




Судалгаанд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн 53 хувь нь СХД-ээс хамрагдсан бол БЗД-ээс 46 хувь, Налайх дүүргээс 1 хувь нь хамрагдсан байна.

График 4. Судалгаанд хамрагдсан дүүрэг, сурагчдаар



Судалгаанд хамрагдсан багш нарын 67 хувь нь сургууль, цэцэрлэгтээ 9 болон түүнээс дээш жил ажилласан байна.

График 5. Багш нарын ажилласан жил




Судалгаанд оролцогчдын 39 хувь нь гэр хорооллын хашаа байшинд, 39 хувь нь орон сууцад амьдарч байна. Судалгаанд оролцогчдын сууцны төрлийг график 6-с харна уу.



График 6. Судалгаанд оролцогчдын амьдардаг сууцны төрөл, түүвэрт эзлэх хувиар

## Амьдардаг сууц:



Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 66% нь 800,000-2,000,000 төгрөгийн өрхийн орлоготой байна.

## Хүснэгт 11. Өрхийн сарын дундаж орлого

Өрхийн сарын дундаж орлого	Хувь
200,000 төгрөг хүртэл	1%
200,001 - 400,000 төгрөг	2%
400,001 - 600,000 төгрөг	3%
600,001 - 800,000 төгрөг	9%
800,001 – 1,000,000 төгрөг	20%
1,000,001 – 1,500,000 төгрөг	24%
1,500,001 – 2,000,000 төгрөг	22%
2,000,001 төгрөг болон түүнээс дээш	20%

Төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэгүүдээс судалгаанд оролцогч нар “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд сургууль, цэцэрлэгт хийгдсэн дулаан алдагдлыг бууруулах засварын ажил хийгдсэн талаар мэдэж байгаа нь 62 хувь байна.



62%

Мэдэж байгаа хувь



38%

Мэдэхгүй байгаа хувь

“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд сургууль, цэцэрлэгт хийгдсэн дулаан техникийн засварын ажлыг багш нар хамгийн сайн мэдэж байгаа буюу 83 хувь нь мэдэж байна. Сурагчдын 53 хувь нь дулаан алдагдал бууруулах засварын ажлын талаар мэдэхгүй байна.

## Хүснэгт 12. Сургууль, цэцэрлэгт дулаан техникийн ажил хийгдсэн талаар мэдэж байгаа эсэх, судалгаанд оролцогчдоор

Судалгаанд оролцогчид	Мэднэ	Мэдэхгүй
Асран хамгаалагчид, Эцэг, эх	48%	52%
Сурагч	47%	53%
Багш	83%	17%

## 5.2. Төсөл хэрэгжсэн сургууль цэцэрлэгийн орчны тав тухын үнэлгээ

### ТӨСӨЛД ХАМРАГДСАНЫ ДАРААХ ОРЧНЫ СЭТГЭЛ ХАНАМЖ


#### 21 ФУНКТЭЭР ӨССӨН БАЙНА

Судалгаанд оролцогчид буюу сурагчид, эцэг эхчүүд, багш нар төсөл хэрэгжихээс өмнө сургууль, цэцэрлэгийн орчны тав тухад 65 хувийн сэтгэл ханамжтай байсан бол сургууль, цэцэрлэгт дулаан алдагдлыг бууруулах засварын ажил хийгдсэний дараа орчны тав тухтай байдлын сэтгэл ханамж 86 хувь болж өссөн байна.

Төсөл хэрэгжихээс өмнө суралцагчдын 51 хувь нь сургууль, цэцэрлэгтээ ирэхэд даардаг байсан гэж хариулсан бол 30 хувь нь дулаан их алддаг байсан гэж хариулжээ. Энэ нь сурагчид сургуулийн орчиндоо сэтгэл ханамжгүй байхад хамгийн их нөлөөлдөг байжээ.

Дараах зурагт төсөлд хамрагдахаас өмнөх сургууль, цэцэрлэгийн орчны сэтгэл ханамжгүй байсан үзүүлэлтүүдийг харууллаа.

Зураг 12. Сургууль, цэцэрлэгийн орчинд сэтгэл ханамжгүй байсан үзүүлэлтүүд



Дараах хүснэгтэд төсөлд хамрагдахаас өмнөх сургууль, цэцэрлэгийн орчны сэтгэл ханамжгүй байсан үзүүлэлтүүдийг харууллаа.

Хүснэгт 13. Сургууль, цэцэрлэгийн орчинд сэтгэл ханамжгүй байсан хүчин зүйлс

Сургууль, цэцэрлэгийн орчинд сэтгэл ханамжгүй байсан хүчин зүйлс	Хувь
Даардаг байсан	51%
Дулаан алдагдал ихтэй байсан	30%
Гаднах орчин муу	12%
Ангидаа зузаан хувцастай суудаг байсан	9%
Анги, танхим тухгүй байсан	9%
Ус алддаг байсан	7%
Ханиад хүрдэг, өвчлөл их байсан	6%

...СУРГУУЛЬ ДЭЭР ДААРААД ЗУЗААН ХУВЦСАА ӨМСӨӨД ХИЧЭЭЛДЭЭ СУУХААР ТҮҮРТЭЭД АНХААРАЛ ТӨВЛӨРДӨГГҮЙ БАЙСАН.




#### ШИГТГЭЭ 1

“Төсөл хэрэгжихээс өмнө манай сургуулийн цонхуудын гадна тал нь хагарчихсан скочоор наасан байсан. Модон цонхтой байсны улмаас сурагчид их даардаг, цонхоо онгойлгохоор ангид шороо, тоос их орж ирдэг байсан. Анги танхим хүйтэн учир сурагчид хичээлдээ зузаан хувцастай суудаг байсан нь **ХӨДЛӨХӨД ИХ ХЭЦҮҮ, ТҮҮРТЭЭД ХИЧЭЭЛДЭЭ АНХААРЧ ЧАДДАГГҮЙ БАЙСАН.** Одоо сурагчид дүрэмт хувцастайгаа л хичээлдээ суудаг болсон. **НАДАД СУРГУУЛИЙН ОРЧИН ИХ ТААЛАГДАЖ БАЙГАА.**

СХД-ийн 65 дугаар сургуулийн 126 ангийн сурагч, эрэгтэй

Судалгаанд оролцогчид буюу сурагчид, эцэг эхчүүд, багш нарт төсөл хэрэгжихээс өмнө тулгардаг байсан асуудлууд буюу /Хүйтэн, дулаан алдагдал ихтэй, ангидаа зузаан хувцастай суудаг/ байсан зэрэг асуудлууд сургууль, цэцэрлэгт дулаан техникийн засварын ажил хийгдсэнээр шийдвэрлэгдсэн гэж 95 хувь нь хариулсан байна. Харин эдгээр асуудлуудын шийдвэрлэгдсэн байдалд сурагчид, эцэг, эх багш нар 92 хувийн сэтгэл ханамжтай байна.

График 7. Асуудлуудын шийдвэрлэгдсэн байдал болон сэтгэл ханамж



Төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн орчны тав тухтай байдлын сэтгэл ханамжийг харьцуулан харлаа. Сургууль, цэцэрлэгт дулаан техникийн засварын ажил хийгдэхээс өмнө цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг, эх багш нар цэцэрлэгийн тав тухтай байдалд 62 хувийн сэтгэл ханамжтай байсан байна. Харин цэцэрлэгт дулаан техникийн засварын ажил хийсний дараа буюу одоогийн цэцэрлэгийн тав тухтай байдалд 92 хувийн сэтгэл ханамжтай болж 30 функтээр өссөн байгааг хүснэгт 7-с харна уу.

Хүснэгт 14. Төсөлд хамрагдсан сургууль цэцэрлэгийн орчны тав тухын харьцуулан үнэлгээ

Харьцуулалт	Сургууль	Цэцэрлэг
Орчны тав тухын өмнөх сэтгэл ханамж	67%	62%
Орчны тав тухын дараах сэтгэл ханамж	83%	92%

ХҮҮХДҮҮД СУРГУУЛЬ ДЭЭРЭЭ БАЙХ ДУРГУЙ БАЙСАН Ч ОДОО ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ИДЭВХ НЭМЭГДСЭН.



88 дугаар сургуульд 2 хүүхэд нь суралцдаг аав, 38 настай.

## ШИГТГЭЭ 2


88-р сургууль хотын төвөөс алслагдсан хонхорт байдаг сургууль болохоор дулааны шугамд холбогдоогүй байсан. Анги, танхим их хүйтэн хүүхдүүд гадуур хувцастайгаа хичээлдээ суудаг байлаа. **ХҮҮХДҮҮД СУРГУУЛЬ ДЭЭРЭЭ БАЙХ ДУРГУЙ ХИЧЭЭЛЭЭ ТАРМАГЦ ГЭР РҮҮГЭЭ ЯВДАГ БАЙСАН.**

Сургуулийн барилга хананаасаа дулаан алддаг, дээврээс нь ус гоождог, сургуулийн булан тохой хэсэг, хананууд мөөгөнцөртсөн, өнгө үзэмжгүй байсан. **СУРГУУЛИЙН ОРЧИН НЬ ХҮҮХДҮҮД ХИЧЭЭЛ, СУРЛАГАДАА ИДЭВХТЭЙ БАЙХ, НЭМЭЛТ ДУГУЙЛАН СЕКЦЭД ЯВАХ ЗЭРЭГТ ИХ НӨЛӨӨЛДӨГ ЮМ БАЙНА.** Өмнө нь сургуулийн дээвэр янзлах, будах зэрэг олон урсгал засварууд хийгддэг байсан. Энэ нь их үр дүн муутай байдаг байсан. Барилгын дээврийг нь янзлаад дулаан алдагдал буурдаггүй, хана, тааз, цонх гээд цогцоор нь шийдэж байж дулаан алдагдал буурдаг юм байна. **СУРГУУЛИЙН ОРЧИН САЙЖИРСНААР ХҮҮХДҮҮДЭЭ ДААРЧ БАЙГАА БОЛОВ УУ ГЭХ МЭТ САНАА ЗОВИНОЛ БАГАСЧ АЖЛАА ТАЙВАН ХИЙДЭГ БОЛСОН.**

Судалгаанд оролцогчид буюу сурагчид, эцэг эх, багш нараар сургууль, цэцэрлэгийн орчны тав тухыг төсөл хэрэгжихээс өмнө болон төсөл хэрэгжсэний дараах орчны сэтгэл ханамжийн ялгааг харьцууллаа.

Үүнээс харахад сурагчид сургуульд дулаан техникийн засварын ажил хийхээс өмнө сургуулийн орчны тав тухдаа 67 хувийн сэтгэл ханамжтай байсан бол сургуульд дулаан техникийн засвар хийгдсэний дараа сургуулийн орчны тав тухад 84 хувийн сэтгэл ханамжтай болж өссөн байна.

*График 8. Орчны тав тухын сэтгэл ханамж, судалгаанд оролцогчдын бүлгээр*



**ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН:** Төсөлд хамрагдахаас өмнө сургууль, цэцэрлэгт орчны, нийгэм, эдийн засгийн дараах асуудлууд тулгардаг байсан байна.

*Хүснэгт 15. Төсөл хэрэгжсэн сургууль, цэцэрлэгүүдийн өмнө нь тулгардаг байсан асуудлууд*

<b>Орчны асуудлууд</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Ангиуд маш хүйтэн учраас даардаг байсан.</li> <li>• Дулаан алдагдал ихтэй. Цонхнууд цантдаг, зарим цонх модон, хаалга, хана, таазнаас салхи сийгдэг. Зарим хана цууралттай байсан.</li> <li>• Булангийн, сүүдэр талдаа цонхтой ангиудыг, наран талдаа цонхтой ангиудтай харьцуулахад маш хүйтэн байсан.</li> <li>• Төвийн шугамд холбогдоогүй болохоор уурын зуухны галлагаа тогтворгүй заримдаа сайн халаад заримдаа маш муу халдаг байсан.</li> <li>• Зөөврийн усан хангамжтай. Зарим сургууль цэцэрлэгүүд нь ойролцоох гол горхиос усаа зөөдөг байсан.</li> <li>• Хүйтэн устай байсан. Жишээ нь самбарын алчуур норгох, цэвэрлэгээ хийхэд гар даардаг байсан.</li> <li>• Анги хүйтэн учраас цонх онгойлгож болохгүй тул олон хүүхдийн амьсгаанд цонх цантдаг байсан. Иймээс ангийн агааржуулалт муутайгаас үүдэн анги чийгтэй, бүгчим үнэртэй болдог байсан.</li> <li>• Сантехникийн асуудал их. Олон жилийн турш засвар шинэчлэлт хийгдээгүй учраас цахилгаан техникийн утас муудах, шугам задрах зэрэг асуудлууд гардаг.</li> <li>• Ариун цэврийн өрөө гадаа байсан. 5-10 минутын завсарлагаанаар бие засаж амжилгүй хичээлдээ хоцроод багш нарт загнуулах мөн бага ангийн хүүхдүүд нойл руу яарч нимгэн хувцастай гарах зэргээс үүдэн ханиад, хатгаа зэрэг өвчлөлд өртөмхий байсан.</li> <li>• Дээврээс ус гоождог байсан. Үүнээс болоод цахилгаан техникийн утас муудаж тог их тасардаг байсан.</li> </ul>
<b>Нийгмийн асуудлууд</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Дүрэмт хувцасны гадуур янз бүрийн хувцас өмсөхөөр эмх цэгцгүй байдаг байсан.</li> <li>• Зузаан хувцастай хичээлдээ тухгүй баригдмал суудаг байсан.</li> <li>• Хүйтэн, тав тухгүй учраас багш ажилчдын бүтээмж буурсан.</li> <li>• Шинээр багш ажилд авахаар орчин нөхцөл тав тухгүй байхаар удахгүй ажлаасаа гарна. Үүнээс үүдэн хүний нөөц дутмаг байсан.</li> <li>• Сургууль хүйтэн учраас хүүхдүүд цэцэрлэг, сургуульдаа явах дургүй байсан.</li> <li>• Хүйтэн үед буюу өвлийн улиралд суралцах хүүхдийн тоо багасдаг байсан.</li> <li>• Хүйтэн учраас хүүхдүүд сургууль дээрээ өөрийгөө хөгжүүлэх нэмэлт дугуйлан, секц, давтлагад хамрагдах идэвх маш муу байсан.</li> <li>• Ханиад, томуу, хоолой өвдөх өвчлөл их байдаг байсан.</li> <li>• Хүүхдүүд өвдсөнөөр аав, ээж нь ажлаасаа чөлөө авах, цалингаа бүтэн авч чадахгүй байх, хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүс орлогогүй болох, зээлээ төлж чадахгүй байх гэх мэт асуудлууд байсан.</li> <li>• Эцэг эхчүүдээс гомдол тасардаггүй байсан.</li> </ul>
<b>Эдийн засгийн асуудлууд</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Эцэг, эх нараас төлөвлөгдөөгүй урсгал зардлууд их гардаг байсан. Дээврээс ус гоожоод ийм асуудал гарсан тул үүнийг засаад янзлаад өгөх эцэг, эх байна уу? Гэх мэт урсгал зардлууд гардаг байсан.</li> <li>• Сургууль, цэцэрлэг эдийн засгийн хувьд үрэлгэн байсан. Жил болгон засвар хийдэг. Материалын зардал их байсан. Хэмнэлт хийж чаддаггүй байсан.</li> </ul>



### 5.3. Төсөл хэрэгжээгүй сургууль цэцэрлэгийн орчны тав тухын үнэлгээ

Дулаан техникийн засварын ажил хийгдээгүй сургууль, цэцэрлэгийн сурагчид, эцэг, эх, багш нар орчны тав тухтай байдалд 66 хувийн сэтгэл ханамжтай байна.

**ТӨСӨЛД ХАМРАГДААГҮЙ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ОРЧНЫ ТАВ ТУХЫН СЭТГЭЛ ХАНАМЖ ТӨСӨЛД ХАМРАГДСАН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГТЭЙ ХАРЬЦУУЛАХАД 20 ХУВИАР БАГА БАЙНА.**

Судалгаанд оролцогчдоос сургууль, цэцэрлэгийн орчны температурт тухтай байж чаддаг уу? Гэж асуухад төсөлд хамрагдсан цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг эх, багш нар орчны температуртаа тав тухтай байж чаддаг гэж 93 хувь нь хариулсан байна. Харин төсөлд хамрагдаагүй цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг, эх, багш нар орчны температуртаа

тухтай байж чаддаг гэж 56 хувь нь хариулсан байна. Үүнээс харахад орчны температуртаа төсөлд хамрагдаагүй сургууль, цэцэрлэг илүү сэтгэл ханамжгүй байна.

График 9. Орчны температурт тухтай байдал, төсөл хэрэгжсэн болон хэрэгжээгүй сургууль, цэцэрлэгээр



#### ХАНИАД ТОМУУ ТУСДАГ.



АМГАЛАН ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН АХЛАХ БҮЛГИЙН СУРГУУЛЬ

#### ШИГТГЭЭ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖЭЭГҮЙ СУРГУУЛИЙН СУРАГЧ

Бүх анги хүйтэн учраас ямар ч ангид орсон гадуур хувцастайгаа суудаг. Энэ жил урлагийн үзлэг болох гээд хичээлээ тараад сургууль дээрээ 7 хоног бүжиг бэлдсэн. **АНГИАРАА ХАНИАД ХҮРСЭН.** Манай ангид бие султай нэг охин байгаа тэр охиныг байнга паарны хажууд суулгадаг. Халуун хүйтэн хавсраад өвлийн улиралд ханиад их болдог. Сургуулийн эмч дээр очихоор буцалсан ус өгөөд л буцаадаг. **СУРГУУЛИЙН ЭМЧИЙГ ЧАНАРЖУУЛАХ ХЭРЭГТЭЙ БАЙНА.** Цонхоо онгойлгохоор даараад агааржуулагч ажиллуулах гэхээр дуу чимээ ихтэй учраас багш дургүйцээд байдаг. **БИ ЭНЭ ЖИЛ ХААЛГАНЫ ХАЖУУД СУУСАН. ИХ ДААРСАН.** Амгалан цогцолбор сургуулийн 126 ангийн эмэгтэй сурагч

Дулаан техникийн засварын ажил хийсэн болон хийгээгүй сургууль, цэцэрлэгээр орчны температурын сэтгэл ханамжийг харьцуулан хүснэгт 8-д харууллаа.

Төсөлд хамрагдаагүй сургууль, цэцэрлэгийн орчны температурыг төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэгтэй харьцуулахад дундаж буюу 60-70 хувийн сэтгэл ханамжтай байна. Тухайлбал төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн анги танхим илүү дулаахан байна гэж сурагчид, эцэг, эх, багш нар үнэлгээ өгчээ.

*Хүснэгт 16. Сургууль, цэцэрлэгийн орчны температурын сэтгэл ханамж, сургуулиудаар*

Төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэг	Дундаж оноо
СХД-ийн 158-р цэцэрлэг	10
СХД-ийн 91-р цэцэрлэг	10
БЗД-ийн 147-р цэцэрлэг	9

БЗД-ийн 55-р сургууль	9
БЗД-ийн 63-р цэцэрлэг	9
Налайх дүүргийн 152-р цэцэрлэг	9
СХД-ийн 80-р цэцэрлэг	9
БЗД-ийн 62-р цэцэрлэг	9
БЗД-ийн 115-р цэцэрлэг	9
БЗД-ийн 53-р сургууль	8
БЗД-ийн 88-р сургууль	8
СХД-ийн 90-р цэцэрлэг	8
СХД-ийн 74-р сургууль	8
СХД-ийн 79-р цэцэрлэг	8
СХД-ийн 65-р сургууль	8
СХД-ийн 127-р цэцэрлэг	8
СХД-ийн 148-р цэцэрлэг	8
СХД-ийн 81-р цэцэрлэг	7
<b>Төсөлд хамрагдаагүй сургууль, цэцэрлэг</b>	<b>Дундаж оноо</b>
БЗД-ийн Амгалан цогцолбор /Төсөлд хамрагдаагүй/	7
СХД-ийн 42-р сургууль /Төсөлд хамрагдаагүй/	7
СХД-ийн 84-р цэцэрлэг /Төсөлд хамрагдаагүй/	7
БЗД-ийн 32-р цэцэрлэг /Төсөлд хамрагдаагүй	6

... БАРИЛГА АКТЛУУЛСАН УЧРААС ГЭР ЦЭЦЭРЛЭГ БАРИАД АЖЛУУЛЖ БАЙГАА. ӨВЧЛӨЛ ИХТЭЙ. ТАВ ТУХГҮЙ. ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ.



СХД-ИЙН 84-Р ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ, ЭМЭГТЭЙ

#### ШИГТГЭЭ 4. ТӨСӨЛ ХЭРЭГЖЭЭГҮЙ ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШ

Манай 84 дүгээр цэцэрлэг 1984 оны хуучны барилга учраас суулт үүссэн, таазаараа хөлөрч мөөгөнцөртсөн зэрэг шалтгаанаар **АКТЛУУЛААД ГЭР ЦЭЦЭРЛЭГ БАРИАД АЖЛУУЛЖ БАЙГАА**. Гэр цэцэрлэгт хүүхэд хичээллэхэд зай талбай хомс учраас гүйж, харайж тоглоход хүндрэлтэй. Агаар сэлгэлт тааруу. 2 залгаа гэр бариад үүдний хэсэгтээ **НОЙЛ БОЛОН ХООЛНЫ ХЭСЭГ ГЭЭД БҮХ ЮМ НЬ ЗЭРЭГЦЭЭ УЧРААС ЭРҮҮЛ АХУЙ ТАЛААСАА АСУУДАЛТАЙ**. Био нойлтой учраас нойлын үнэр их учраас ажиллахад маш хүнд. Халуун ус байхгүй. **ЗӨӨВРИЙН УСТАЙ УЧРААС** цэвэрлэгээ хийх, хүүхдийн даавуу, аяга таваг угаахад гар даарах зэрэг тухгүй мэдрэмж байнга төрдөг. Шалны халаалттай. **ӨГЛӨӨ ХАЛАХ ГЭЖ УДДАГ УЧРААС ХҮҮХДҮҮД ДААРДАГ. 60 ХҮҮХЭД СУРЧ БАЙГААГААС ИХЭНХ НЬ ӨВДСӨН.**

**ЧАНАРЫН СУДАЛГААНААС:** Төсөлд хамрагдаагүй сургууль, цэцэрлэгт орчны, нийгэм, эдийн засгийн дараах асуудлууд тулгардаг байсан байна.

*Хүснэгт 17. Төсөлд хэрэгжээгүй сургууль, цэцэрлэгүүдэд тулгарч буй асуудлууд.*

Орчны асуудлууд	
